

# **“ТӨРӨӨС МАЛЧДЫН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО”-ЫН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2021 оны 03 дугаар сарын 30

## **НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ**

Төрөөс малчдын талаар баримтлах бодлогын 2020 оны хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг хийв. ХХААХҮ-ийн сайдын 2018 оны А-198 дугаар тушаалаар баталсан хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтийг үндэслэж асуудал хариуцсан мэргэжилтнүүдээс шаардагдах тодруулга, холбогдох мэдээлэл, статистик дүнг гаргуулан ажиллав.

## **ХОЁР. БОДЛОГЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 39 дүгээр тогтоолоор "Төрөөс малчдын талаар баримтлах бодлого"-ын баримт бичиг батлагдсан. Бодлогын баримт бичгийн 2 дахь үе шатны хэрэгжүүлэх (2018-2020 оны) арга хэмжээний төлөвлөгөөг ХХААХҮ-ийн сайдын 2018 оны А-198 дугаар тушаалаар баталсан.

### **2.1. Бодлогын зорилго**

Төрөөс малчдын талаар баримтлах бодлогын зорилго нь малчин хүнийг өөрийг нь хөгжүүлэх замаар малчин өрхийн ашиг, орлогыг нэмэгдүүлэн амьдралын түвшинг дээшлүүлэхэд оршино.

### **2.2. Бодлогын үр нөлөө**

Малчид эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд 100 хувь хамрагдаж, төрөөс үзүүлэх нийгмийн халамж, үйлчилгээг хүртэх болно. Малчид аж ахуй эрхлэх, хөдөлмөр, хүчээ хорших мэдлэг, дадлагаа нэмэгдүүлж, тэдний амьдралын нөхцөлд өөрчлөлт гарч, орлогын түвшин 80 хувиар өснө.

### **2.3. Бодлогын зорилт**

Зорилт 1. Малчдыг орон нутагтаа тав тухтай ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, ядуурлаас ангид байлгах, тэдэнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын баталгаа бий болгоход чиглэсэн эрх зүй, эдийн засаг, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх;

Зорилт 2. Малчин өрхийн эдийн засгийн үндэс болсон мал аж ахуйн үйлдвэрлэлийн зохион байгуулалтыг сайжруулж бүтээмж, чанар, үр ашгийг дээшлүүлэх, бүтээгдэхүүн борлуулах зах зээлийн оновчтой тогтолцоо бий болгох;

Зорилт 3. Малчдын өөрөө өөртөө туслах, өөрөө өөрийгөө удирдах иргэний нийгмийн бүтцийг бий болгон хөгжүүлэхийг дэмжих, боловсрол, мэдлэг чадварыг дээшлүүлэх, тусгай мэргэжил эзэмшүүлэх, малчдад үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах замаар амьдралын дадал, заншилд өөрчлөлт оруулах;

### **2.4. Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх хугацаа**

-Эхний үе шат 2009-2015 он,  
-Хоёрдахь үе шат 2016-2020 он.

### **2.5. Бодлогын баримт бичгийн 2 дахь үе шатны хүрэх үр дүн**

1. Малчид эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд 100 хувь хамрагдаж, төрөөс үзүүлэх нийгмийн халамж, үйлчилгээг хүртэх болно;
2. Малчид аж ахуй эрхлэх, хөдөлмөр, хүчээ хорших мэдлэг, дадлагаа нэмэгдүүлж, тэдний амьдралын нөхцөлд өөрчлөлт гарна;
3. Малчдын орлогын түвшин 80 хувиар өснө.

## **ГУРАВ. ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН**

Төрөөс малчдын талаар баримтлах бодлогын хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт 2020 оны жилийн эцсийн байдлаар 86.6 хувьтай байна.

№	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин (2020 он)	Хүрсэн түвшин	Үнэлгээ
1	Малчид эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд хамрагдаж, төрөөс үзүүлэх нийгмийн халамж, үйлчилгээг хүртэх, (хувиар)	100	75	75
2	Малчид аж ахуй эрхлэх, хөдөлмөр, хүчээ хорших мэдлэг, дадлагаа нэмэгдүүлж, тэдний амьдралын нөхцөлд өөрчлөлт гарна, (Үйл ажиллагаагаар)	Бизнесийн тогтвортой, үр ашигтай, өргөтгөсөн нөхөн үйлдвэрлэл эрхэлдэг малчдын бүлэг, фермер, хоршоо, нөхөрлөлийн хэв шинжээр аж ахуй шинээр байгуулагдаж үйл ажиллагаа нь тогтворжсон байна.	Улсын хэмжээнд 4274 малчдын бүлэг, фермер, хоршоо, нөхөрлөлийн хэв шинжит аж ахуй үйл ажиллагаа явуулж байна. 2020 онд 214 хоршоо шинээр байгуулагдаж нийт малчдын 68 хувь буюу 179.2 мянган малчин хамрагдаж мал аж ахуй эрхлэх, хөдөлмөр, хүчээ хорших мэдлэг, дадлагаа нэмэгдүүлж, ахуй нөхцлөө сайжруулж байна.	85
3	Малчдын орлогын түвшин өснө, (хувиар)	80	85	100
<b>Нийт</b>				<b>86.6</b>

Төрөөс малчдын талаар баримтлах бодлогын 2020 оны арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр нийт 46 арга хэмжээнээс 28 арга хэмжээ 100 хувь, 10 арга хэмжээ 90 хувь, 7 арга хэмжээ 70 хувь, 1 арга хэмжээ 50 хувийн хэрэгжилттэй тус тус дүгнэгдэж, ерөнхий үнэлгээ дунджаар 92.8 хувь байна.

### Төрөөс малчдын талаар баримтлах бодлогын 2020 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн

д/д	Зорилт	Арга хэмжээний тоо	Үнэлгээ, хувь					Дундаж үнэлгээ	
			100	Тодорхой үр дүнд хүрсэн		Эрчимжүүлэх шаардлагатай			0
				90	70	50	30		
1	Зорилт-1	12	6	5	1			93.3	
2	Зорилт-2	21	12	3	5	1		89.0	
3	Зорилт-3	13	10	2	1			96.1	
<b>Нийт</b>		<b>46</b>	<b>28</b>	<b>10</b>	<b>7</b>	<b>1</b>		<b>92.8</b>	

Зорилт 1. “Малчдыг орон нутагтаа тав тухтай ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, ядуурлаас ангид байлгах, тэдэнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын баталгаа бий болгоход чиглэсэн эрх зүй, эдийн засаг, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх”-ийн хүрээнд 12 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж ажилласан бөгөөд 1 дүгээр зорилтын хэрэгжилтийн дундаж 93.3 хувь байна. Нийт 12 арга хэмжээнээс 100 хувь хэрэгжсэн 6 арга хэмжээ, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70-90 хувийн хэрэгжилттэй 6 арга хэмжээ байна.

Зорилт 2. “Малчин өрхийн эдийн засгийн үндэс болсон мал аж ахуйн үйлдвэрлэлийн зохион байгуулалтыг сайжруулж бүтээмж, чанар, үр ашгийг дээшлүүлэх, бүтээгдэхүүн борлуулах зах зээлийн оновчтой тогтолцоо бий болгох”-ийн хүрээнд 21 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж ажилласан бөгөөд 2 дугаар зорилтын хэрэгжилтийн дундаж 89.0 хувь байна. Нийт 21 арга хэмжээнээс 100 хувь хэрэгжсэн 12 арга хэмжээ, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70-90 хувийн хэрэгжилттэй 8 арга хэмжээ, эрчимжүүлэх шаардлагатай буюу 50 хувийн гүйцэтгэлтэй 1 арга хэмжээ байна.

Зорилт 3. “Малчдын өөрөө өөртөө туслах, өөрөө өөрийгөө удирдах иргэний нийгмийн бүтцийг бий болгон хөгжүүлэхийг дэмжих, боловсрол, мэдлэг чадварыг дээшлүүлэх, тусгай мэргэжил эзэмшүүлэх, малчдад үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах замаар амьдралын дадал, заншилд өөрчлөлт оруулах”-ийн хүрээнд 13 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж ажилласан

бөгөөд 3 дугаар зорилтын хэрэгжилтийн дундаж 96.1 хувь байна. Нийт 13 арга хэмжээнээс 100 хувь хэрэгжсэн 10 арга хэмжээ, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70-90 хувийн хэрэгжилттэй 3 арга хэмжээ байна.

### **ДҮГНЭЛТ**

1. Төрөөс малчдын талаар баримтлах бодлогын хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт 2020 оны жилийн эцсийн байдлаар 86.6 хувь, 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 92.8 хувьтай байна. Үүнээс 28 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, тодорхой үр дүнд хүрсэн 17 арга хэмжээ, эрчимжүүлэх шаардлагатай 1 арга хэмжээ байна.
2. 2019 онтой харьцуулахад 2020 оны хэрэгжилтийн үнэлгээ 18.7 хувиар өссөн байна. Энэхүү бодлогын хэрэгжилтийн үр дүнд сүүлийн жилүүдэд малчдын бүлэг, фермер, хоршоо, нөхөрлөлийн хэв шинжит аж ахуй шинээр байгуулагдах нь нэмэгдэж малчдын орлогын түвшин 85 хувиар өссөн үзүүлэлттэй байна. 2020 онд 214 хоршоо шинээр байгуулагдаж нийт малчдын 68 хувь буюу 179.2 мянган малчин хамрагдаж байна.
3. 2020 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлуулаагүй, ХХААХҮ-ийн сайдын 2018 оны А-198 дугаар тушаалаар баталсан арга хэмжээний төлөвлөгөө нь хүрэх үр дүн тодорхойгүй, хэмжих боломжгүй үзүүлэлтээр баталсан нь үр дүнгийн өөрчлөлтийг хэмжиж, бодит үнэлгээ өгөхөд бэрхшээлтэй байв.

### **ЗӨВЛӨМЖ**

1. Бодлогын баримт бичгийг хэрэгжилтийг хангахад хамтран оролцох салбар хоорондын уялдааг сайжруулж ажиллахыг холбогдох бүх газарт;
2. МУ-ын ЗГ-ын 2020 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол малчин" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллахыг МААБХЗГ-т;
3. Тухайн жилийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хамтран хэрэгжүүлэх салбарын бүх байгууллагуудад хүргүүлэх, арга хэмжээ бүрт хариуцан ажиллах байгууллага, албан тушаалтныг тусгаж ажиллахыг холбогдох бүх газарт;
4. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу бодлогын хэрэгжилтийг хугацаанд нь тайлагнаж, цахим санд баталгаажуулахыг холбогдох бүх газарт;

ТӨРӨӨС МАЛЧДЫН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2020 оны жилийн эцэс

Д/д	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2020 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Нэгдсэн дүгнэлт	Үнэлгээ
<p>2.1. Малчдыг орон нутагтаа тав тухтай ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, ядуурлаас ангид байлгах, тэдэнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын баталгаа бий болгоход чиглэсэн эрх зүй, эдийн засаг, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх бодлогын чиглэлийн хүрээнд дараахь стратегийн зорилт дэвшүүлэн хэрэгжүүлнэ:</p>						
1	<p>2.1.1. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч болон малчны бүлэг, хоршоо, нөхөрлөл, малчин өрхөд мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэхэд хүрэлцэх хэмжээний газрыг эзэмшүүлэх, отрын бүс нутаг байгуулах, сумдад бэлчээр ашиглалтын хороог ажиллуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх;</p>	2009 - 2020			<ol style="list-style-type: none"> <li>3Г-ын 2018 оны 131 дүгээр тогтоолоор тариалангийн бүс нутгийг тогтоож, 7 аймгийн 60 сум, 113 багийн тариалангийн бүс нутагт зөвхөн ЭМАА эрхлэх бөгөөд тариалан эрхлэгч аж ахуйн нэгжүүд талбайн тодорхой хэсэгтээ тэжээл тариалж, малчдаа дэмжих зохицуулалт бий болгосон.</li> <li>“Нийслэлийн эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийн хүрээнд Нийслэл орчимд эрчимжсэн аж ахуйг цогц байдлаар хөгжүүлэх чиглэлээр суурьшлын 3 бүсийг шинээр бий болгосон.</li> <li>“Ногоон алт малын эрүүл мэнд” төслийн 46.7 сая₮-ийн санхүүжилтээр 8 аймагт орон нутгийн тусгай хэрэгцээний отрын нөөц бэлчээрийн судалгаа хийснээр нийт 5187.7 мян га бэлчээрийг орон нутгийн тусгай хэрэгцээний отрын нөөц бэлчээр болгож, хил заагийг газрын нэгдмэл сангийн мэдээллийн санд оруулах ажлыг аймгуудын Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар хийж байна. Мөн тус төсөлтэй хамтран 21 аймгийн 186 суманд 1362 бэлчээр ашиглагчдын хэсэг байгуулж, 11 аймгийн 830 бэлчээр ашиглагчдын хэсэг сумын Засаг даргатай бэлчээр ашиглах гэрээг 15 жилийн хугацаатай байгуулан бэлчээрийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулж байна.</li> <li>“Мерси кор” ОУБ-ын “Гамшгийн эрсдэлийг бууруулахад уламжлалт болон шинжлэх ухааны аргыг ашиглах нь” төсөлтэй хамтран МАА-н эрсдэлийг бууруулах, бэлчээрийн ашиглалт, хамгаалалт сайжруулах зорилгоор 11 аймгийн 45 суманд 2019-2022 онд хэрэгжих дунд хугацааны бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулан сумдын ИТХ-аар батлуулж, бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж байна.</li> <li>“Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил нэмэлт санхүүжилт” төсөл хэрэгжиж буй 6 аймгийн 18 суманд 50 малчдын бүлэг</li> </ol>	90%

					<p>бэлчээрийн даацад малын тоог тохируулах, талхлагдсан бэлчээрийг зохистой ашиглан сайжруулж, нийт 120.0 мян га бэлчээрийг сэлгэн өнжөөж сайжруулав.</p> <p>6. УИХ-ын 2020.11.13 өдөр “Малын тоо толгойн албан татварын тухай хууль”-ийг хэлэлцэн, баталж 2021.01.01-ний өдрөөс хэрэгжиж эхлээд байна.</p>	
2	<p>2.1.2. Хувь хүний орлогын албан татвараас малчин өрхийг чөлөөлж, бэлчээр ашигласны төлбөрийг эдийн засаг, экологийн үнэлгээнд үндэслэн ялгавартай тогтоох, уг төлбөрийн 30-аас доошгүй хувиар сумын бэлчээр хамгаалах, сэргээх болон мал аж ахуйн эрсдлийн сан байгуулж, зарцуулж байхаар эрх зүйн зохицуулалтыг бий болгох;</p>	2009 - 2020	-		<p>1. Улсын Их Хурал 2020 оны 11 дугаар сарын 13-ны өдөр Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа малын тоо толгойд албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилт бүхий малын тоо, толгойн албан татварын тухай хуулийг батлан гаргасан. Энэхүү хуулиар Монгол улсын нутаг дэвсгэр байгаа бүх малаас малын төрөл тус бүрт 0-2000 төгрөгийн татвар ногдуулах бөгөөд татварын орлогыг орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэн, зарцуулахаар төсвийн тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулан хуульчилсан. Малын тоо, толгойн албан татварын орлогыг мал аж ахуйн үйлдвэрлэл, бэлчээрийн менежментийг сайжруулах зэрэг мал аж ахуйн салбарын 13 үйл ажиллагаанд зарцуулах төсвийн тухай 60.2.8 дахь заалтаар тодорхой заасан. Малын тоо толгойн албан татварын тухай хуулиар тогтоосон 0-2000 төгрөгийн хязгаарт багтаасан нэг малаас авах албан татварын хэмжээг сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал тогтоохоор заасан.</p> <p>2. 2020 онд бэлчээрийн менежментийг сайжруулах ажлын хүрээнд бэлчээрийн усан хангамжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хэмжээг өмнөх оны түвшинтэй харьцуулахад төсвийн хөрөнгө оруулалт 470 сая төгрөгөөр, төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалт 2.5 тэрбум төгрөг буюу 38.5 хувиар тус тус нэмэгдүүлсэн. Харин орон нутаг болон малчдын санаачилгаар гаргах хөрөнгө оруулалт 400 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.</p> <p>3. НҮБ-ын ХХААБ, Хөдөө аж ахуйг дэмжих олон улсын сан, Швейцарийн хөгжлийн агентлаг, Мерси кор Монгол зэрэг байгууллагуудын хүрээнд байгуулагдсан нийт 18 аймгийн 165 сумын 1630 малчдын бүлэг /бэлчээр ашиглагчдын хэсэг/ бэлчээр ашиглах гэрээг сумын Засаг даргатай байгуулан бэлчээрээ хамгаалан ажиллаж байна. Эдгээрээс бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг газрын нэгдмэл сангийн мэдээллийн санд бүртгүүлэн баталгаажуулсан нь 900 гаруй байна.</p>	100%

3	2.1.3. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч болон малчдын бүлэг, хоршоо, нөхөрлөл, малчин өрхийг мал, амьтан, эд хөрөнгийн даатгал, санхүү, бүртгэлийн нэгдсэн тогтолцоонд хамруулах, хөрөнгийн гэрчилгээ, харилцах данс, бүртгэлтэй болгож банк, санхүүгийн байгууллагаас зээл авах, лизингийн үйлчилгээнд хамрагдах эрх зүйн орчныг бүрдүүлэх;	2009 - 2020		<ol style="list-style-type: none"> <li>1. Улсын хэмжээнд 2020 онд 51.3 мянган малчин сайн дурын нийгмийн даатгалд хамрагдсан. Мал эрсдлийн даатгалын ач холбогдолыг малчдад сурталчилж ажилласнаар энэ онд 21 аймгийн 18.3 мянган малчин өрхийн 5,193.0 сая толгой малыг малын эрсдлийн даатгалд хамруулсан. 2020 онд Малын индексжүүлсэн даатгалаар 33,894 малчин өрхийг даатгалд хамруулж, 4,0 тэрбум гаруй төгрөгийн хураамжийн орлогыг төвлөрүүлсэн. Даатгуулсан малчин өрх нь нийт малчин өрхийн 23.08 хувийг эзэлж байгаа бөгөөд өнгөрсөн онтой харьцуулахад даатгалын хураамжийн орлого 495.0 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.</li> <li>2. “Малчин өрхийг үндэсний үйлдвэрлэгчээр бүртгэх, гэрчилгээ, баталгааны тэмдэг, малчинд мэргэжлийн үнэмлэх олгох, хэрэглэх журам”-ын төслийг шинэчлэн боловсруулж 2020 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн ХХААХҮ-ийн сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн зөвлөлөөс гарсан зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан төслийг 2021 оны 2-р улиралд батлуулахаар ажиллаж байна.</li> </ol>	70%
4	2.1.4. Малчин өрх, малчдын бүлэг, хоршоо, нөхөрлөл нь бизнесийн өөр төрлийн үйл ажиллагаанаас орлого олох боломж, нөхцөлийг бүрдүүлэх;	2009 - 2020		<ol style="list-style-type: none"> <li>1. Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо нь “ХАА-н хөгжлийг дэмжих олон улсын сан” /IFAD/-ийн Монгол Улсыг хариуцсан захирал Үберт Бойрард-тай хамтын ажиллагааны санамж бичиг 2020 оны 01-р сарын 27-ны өдөр байгуулж гарын үсэг зурлаа. Энэхүү санамж бичгийг байгуулснаар “ХАА-н хөгжлийг дэмжих Олон улсын сан”-аас хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрүүдийг хамтран хэрэгжүүлэх, Үндэсний холбооны гишүүн хоршоодыг төсөл хөтөлбөрт хамруулах боломж нээгдсэн байна. Санамж бичгийн хүрээнд “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн нэмэлт санхүүжилтээр төслийн зорилтот аймгуудын орон нутгийн бага дунд орлоготой иргэдийн орлогыг бодитоор нэмэгдүүлэн тэдгээрийн амьжиргааг тогтвортой болгох зорилгоор гишүүн хоршооддоо чадавхийн үнэлгээ хийх, 4P бизнес төлөвлөгөө боловсруулах ажлыг зохион байгуулан ажилласан байна.</li> <li>2. ОУ-ын хөдөлмөрийн байгууллагаас хэрэгжүүлж буй “Малчдын нийгмийн хамгааллыг өргөжүүлж, цочролд бэлэн байх чадавхийг нэмэгдүүлэх нь” төсөл нь 2020 оны 07-р сараас 2021 оны 12 сар хүртэлх хугацаанд Завхан аймгийн Их-Уул, Тэс, Отгон, Дөрвөлжин, Идэр сумдад хэрэгжиж байна.</li> <li>3. Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо, Хөдөөгийн тогтвортой хөгжлийн төлөөх Азийн фермерүүдийн</li> </ol>	100%

				<p>холбоо /АФХ/-той хамтран “Хоршооллын салбар дах залуучуудын манлайлал, нөлөөлөл” сэдэвт сургалтыг 2020 оны 06-р сарын 25-28-ны өдрүүдэд Үндэсний холбооны хурлын танхимд зохион байгууллаа.</p> <p>4. “Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих” төслийг хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд нийт 24.5 сая ам. долларын хөрөнгөөр газар тариалангийн үйлдвэрлэлд нэн хэрэгцээтэй байгаа техник, тоног төхөөрөмж нийлүүлсэн.</p> <p>5. Монголын ургамал хамгаалал, хяналт үнэлгээ холбоо ТББ-тай хамтран “Уургийн өндөр агууламжтай олон наст царгас тариалж малын тэжээлийн нэр төрлөө нэмэгдүүлье” сэдэвт цахим сургалтыг Дархан, Сэлэнгэ, Улаанбаатар хотод тус тус зохион байгуулж нийт 8500 иргэд, малчдыг хамруулсан.</p>	
5	2.1.5. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн онцлогт нийцсэн хөдөлмөрийн харилцааны хэв шинжийг судалж, туслах малчны хөдөлмөрийн харилцааг зохицуулсан эрх зүйн орчныг бүрдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөгөөтэй уялдуулан орлого багатай малчдыг өөр салбарт шилжин ажиллах, бизнес эрхлэхийг дэмжих тусгай хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх;	2009 - 2020	-	<p>1. Малчдын хөдөлмөрийн харилцааг сайжруулах ажлын хүрээнд иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, байнгын ажилтай, тогтмол орлоготой болгох, малчин ажил олгогч болон туслах малчдын хөдөлмөрийн харилцааг сайжруулах зорилгоор хот суурин газраас хөдөө, орон нутагт шилжин суурьшиж, олон малтай малчны малыг гэрээгээр маллах, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр “Гэрээт малчин–өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих туршилтын төсөл”-ийг 2018 оны 8 дугаар сараас хэрэгжүүлсэн. Үүнд нийт 225 ажил олгогч малчин, 223 гэрээт малчин өрхийн 406 иргэн ажлын байраар хангагдаж 51.0 сая төгрөг зарцуулсан байна. Төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэн ХЭҮЗ-ийн 2019 оны 01 дүгээр тогтоолоор шинэчлэн баталж, хэрэгжүүлж байна. 2013-2020 онд Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт нийт 15841 малчин хамрагдаж, 8759 ажлын байр бий болж 28.1 тэрбум төгрөг зарцуулсан, хэрэгжилт дунджаар 98 хувьтай байсан. Малжуулах арга хэмжээнд 1276 малчин өрхийн 3412 малчин иргэн хамрагдаж 42481 хонь, 58151 ямаа 3226 үхэр 109 адуу худалдан авахад 6.1 тэр бум төгрөг, малчдыг мэдлэгжүүлэх болон залуу халааг бэлтгэхэд чиглэгдсэн мал маллах арга ажиллагааны сургалт, туршлага солилцох уулзалтад 2839 өрхийн 4915 малчин иргэн хамрагдаж 520.1 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.</p>	100%
6	2.1.6. Малчдын хөдөлмөр, нийгмийн хамгааллын эрх зүйн орчныг бүрдүүлж малчдыг	2009 - 2020		<p>1. "Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хууль" баталсан. Энэхүү хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт тэтгэврийн даатгалын шимтгэлийг</p>	90%

	<p>нийгмийн даатгалд заавал хамруулах тогтолцоонд шилжүүлэх, тэдний нийгмийн хамгааллыг сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлэхэд төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн оролцоо, идэвхийг нэмэгдүүлэх;</p>			<p>нөхөн төлүүлэх журмыг Засгийн газар батална гэж заасан. Мөн хуулийн 8 дугаар зүйлд 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө гэж тус тус заасан тул ХНХЯ энэхүү хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хүрээнд Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Энэхүү хөтөлбөрөөр малгүй болон цөөн малтай 18-45 насны өрхийг малжуулах, аж ахуй эрхлэлтийн болон мал маллах арга ажиллагааны сургалтад хамруулах, туршлага солилцох уулзалт, нэгдсэн өдөрлөг яармаг зохион байгуулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлдэг бөгөөд 2020 оны эцсийн байдлаар 5400 гаруй өрхийг хамруулж, 10,898,3 сая төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарцуулсан байна.</p> <p>2. Малчдын нөхөн даатгалын шимтгэлийн тодорхой хувийг улсын төсөв, хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хүрээнд шийдвэрлэж малчдыг нийгмийн даатгалд хамрагдах сэдэл, сонирхлыг төрүүлж ирээдүйд нийгмийн баталгаа нь хангагдах боломжийг бүрдүүлэх, малчдыг 100 хувь нийгмийн даатгалд хамруулах зорилтын хүрээнд Монгол Улсын Их Хурлаас 2017 онд "МАЛЧИН, ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИЙН ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ТУХАЙ"-ийг баталж, нийгмийн даатгалын байгууллага 2022 оны 01 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд уг хуулийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх зохицуулалт хийж өгсөн. Хуулийг хэрэгжүүлэх хугацаанд 2020 оны байдлаар нийт 628.1 мянган малчин, үүнээс 138.0 мянган малчин хамрагдаж 11 хүртэл жил ажилласнаар нөхөн тооцуулсан.</p>	
7	<p>2.1.7. Мал аж ахуйн салбарт хүүхэд хөдөлмөр эрхлэх нөхцөл, шалгуурыг тодорхой болгож, тус салбар дахь хүүхдийн хөдөлмөрийн гэвчишгүй хэлбэрүүдийг арилгах бодлого хэрэгжүүлэх;</p>	2009 - 2020		<p>1. Нийт малчин өрхөд амьдарч буй 5-17 насны хүүхдийн 10 хувь буюу 18,000 гаруй хүүхэд мал аж ахуйн салбарт хөдөлмөр эрхэлж байна. ОУХБ-ын дэмжлэгтэй хийсэн Хүүхдийн хөдөлмөрийн судалгааны 2018 оны тайланд дурдсанаар 15-аас 17 насны хүүхдүүдийн 22 хувь нь мал маллаж байгаагаас сургуульд суралцаж чадаагүй бөгөөд энэ нь хүүхэд сургуульд суралцахгүй байх хамгийн түгээмэл шалтгаан болжээ. Улсын хэмжээнд 2020 оны мэдээгээр 10,000 гаруй хүүхэд морь унаачаар бүртгэгдсэн байна. Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрийг (2017-2021 он) Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоолоор баталсан бөгөөд дээрх асуудлыг шийдвэрлэхэд тодорхой заалтуудыг тусгаж өгсөн болно.</p>	100%



				<p>2. "MNS 2020 Хариуцлагатай нүүдэлчин зохистой дадлыг нэвтрүүлэхэд тавигдах шаардлагууд" стандартын төслийн 7.2-т "мал маллагаа, түүхий эд бэлтгэх ажлыг малчин өөрөө эсвэл насанд хүрсэн хүнийг хяналтандаа хөлслөн ажиллуулна. Насанд хүрээгүй (16 түүнээс доош) хүүхэд ажиллуулахыг хориглоно" гэж зааж оруулсан.</p> <p>3. Аймгийн ХХААГ, Гэр бүл, хүүхэд залуучуудын газар хамтран мал аж ахуйн салбарт зуны амралтаараа ажиллаж байгаа хүүхдүүдийн аюулгүй байдал, эрсдлийг тооцон хүүхдэд тохирсон цагаар ажиллуулах талаар малчдад зөвлөмж өгөх арга хэмжээг зохион байгуулсан. Мөн Хурдан морь, уралдаанч хүүхдийн мэдээллийн санд бүртгэлтэй хүүхдүүдийг эрсдлийн даатгалд хамруулан ажиллаж байна.</p>	
8	2.1.8. Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээс олох орлого, бүтээгдэхүүний чанарыг урамшуулах эрх зүй, эдийн засаг, зохион байгуулалтын арга хэмжээ авах;	2009 - 2020	-	<p>1. Холбогдох стандартын шаардлага хангасан арьс, шир, ноос, ноолуур, сүү, улаанбуудай үйлдвэрлэн дотоодын үйлдвэрт нийлүүлсэн малчид, мал бүхий иргэд, аж ахуй нэгж, үйлдвэрт засгаас газрын шийдвэрээр олгож байгаа урамшууллыг шуурхай, оновчтой зохион байгуулж, мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор <a href="http://www.uramshuulal.gov.mn">www.uramshuulal.gov.mn</a> цахим системийг хөгжүүлэн ашиглалтад оруулав. Уг системд урамшуулалтай холбогдох засгийн газрын болон бусад байгууллагын шийдвэр, журам, заавар зэрэг эрхзүйн баримт бичгүүд, урамшуулалд хамрагдсан малчид, иргэдийн тоо, нийлүүлсэн бүтээгдэхүүний хэмжээ болон урамшуулал шалгах боломжийг нэг дор багтаасан систем юм.</p> <p>2. ХХААХҮСайлбарт 2020 онд татаас, урамшуулалд нийт 248.7 тэрбум төгрөг батлагдсан. Үүнд 242,823 тонн хүнсний улаанбуудай ХААДСан болон гурилын үйлдвэрүүдэд нийлүүлсэн 797 иргэн, аж ахуйн нэгжид 22.4 тэрбум төгрөгийн урамшуулал, 85 үндэсний боловсруулах үйлдвэрт 13,219.3 тонн хонь,тэмээний ноос бэлтгэн тушаасан 46,828 малчин, мал бүхий этгээдэд 19.4 тэрбум төгрөгийн мөнгөн урамшуулал, 12 арьс, шир гүн боловсруулах үйлдвэрт 2,610,197 ширхэг бод, богийн арьс шир бэлтгэн нийлүүлсэн 37,825 малчин, мал бүхий этгээдэд 9.9 тэрбум төгрөгийн мөнгөн урамшуулал, 203,641 малчин, мал бүхий этгээдэд 175.0 тэрбум төгрөгийн ноолуурын мөнгөн урамшуулал олгож ажилласан.</p> <p>3. Засгийн газрын 130 дугаар тогтоолоор батлагдсан “Сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад</p>	100%

					нийцсэн малын түүхий сүү бэлтгэн нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд мөнгөн урамшуулал олгох журам"-ын дагуу сүү боловсруулах 8 үйлдвэр, цехэд 12 дугаар сард 1,533,489 литр түүхий сүүг мал эмнэлгийн гарал үүслийн гэрчилгээтэй, татварын цахим төлбөрийн баримт /и-баримт/ үүсгэн баталгаажуулсан нийт 1643 малчин, 16 эрчимжсэн мал аж ахуйн эрхлэгч аж ахуйн нэгжид Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А-11 дүгээр тушаалын дагуу 766,7 сая төгрөгийн мөнгөн урамшууллыг төрийн сангийн дансаар дамжуулан шилжүүлсэн.	
9	2.1.9. Малчдын бүлэг, хоршоо, нөхөрлөл болон фермерүүд дундын сан байгуулах, улмаар нутгийн иргэдийн санаачилгаар өөрийн санхүүгийн тогтолцоо бий болгох эрх зүйн орчныг бий болгон хөгжүүлэх;	2009 - 2020			<ol style="list-style-type: none"> <li>1. МУ-ын ЗГ-ын 2020 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол малчин" үндэсний хөтөлбөрийн хүрээнд малчдын бүлэг, хоршоо, нөхөрлөл болон фермерүүд дундын сан байгуулах, улмаар нутгийн иргэдийн санаачилгаар өөрийн санхүүгийн тогтолцоо бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлж өгсөн.</li> <li>2. 2019 онд ЖДҮХС-ийн захирлын 2019 оны А/77, А/81, А/117 дугаар тушаалуудаар сүүний чиглэлийн болон махны чиглэлийн үхэр, сарлаг үхрийн, тэмээ, хонь, тахиа, гахай, зөгий, загасны нийт 101 иргэн, аж ахуйд 10 тэрбум 528 сая 490,7 мянган төгрөгний зээлийг 5-н жилийн хугацаатай олгосон. Үр дүн нь малын гаралтай түүхий эдийн үнэ ханшийн уналтаас хамгаалах, малчин өрхийн орлого, амьжиргааны баталгааг хангасан.</li> <li>3. Монгол Улсын Засгийн газраас, Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн газар хоорондын Экспортын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр манай орны газар тариалангийн бүс нутагт 600 үнээ бүхий 6 сүүний эрчимжсэн цогцолбор ферм байгуулах төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөж, төслийн баримт бичгийг 2020 оны 2 дугаар сард зарлан энэ төсөлд оролцохоор нийт 15 аж ахуйн нэгж материалаа ирүүлснээс 5 аж ахуйн нэгжийг эхний ээлжинд сонгон шалгаруулаад байна. Цаашид энэ зээлийг ХААДС-аар дамжуулан олгохоор ажиллаж байна. 2020 оны байдлаар 6 аймгийн 11 хоршоонд 210 сая төгрөгийн бизнес хөгжлийн зээлийг олгосон байна.</li> </ol>	90%
10	2.1.10. Бэлчээрийн мал аж ахуй эрхэлж байгаа малчин өрхийг малын чанараа сайжруулах болон өндөр ашиг шимтэй эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчийг арвин ашиг шимт	2009 - 2020			<ol style="list-style-type: none"> <li>1. Аймаг, нийслэлийн 32 мал үржүүлгийн техникч нартай гэрээ байгуулан ажлыг дүгнэн ажиллаж байна. Зах зээлийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан иргэн, аж ахуй нэгж, албан байгууллага, гэрээт техникч нарын захиалгын дагуу стандартын шаардлага хангасан хосолмол ашиг шимт бухны 4231, сүүний чиглэлийн бухны 1007, махны чиглэлийн бухны 1182, хуц, ухны 1150 тун, нийт 7570</li> </ol>	90%

<p>нэг төрлийн мал дагнан төрөлжүүлэн зах зээлийн мэдээлэл, бизнес төлөвлөгөө бүхий аж ахуйн хэв шинжийг олоход нь дэмжлэг үзүүлэх;</p>				<p>тун гүн хөлдөөсөн үрийг хөнгөлттэй үнээр генийн сангаас олгов. Аймаг, нийслэл, сум дүүргийн МАА-н дарга мэргэжилтэнүүдийн захиалгын дагуу аж ахуйн нэгж, иргэдийн нийт 6953 үнээнд 01-11-р сард зохиомол хээлтүүлгийн ажил үйлчилгээ үзүүлэн хээлийн шалгалтаар 85.6 хувийн үр дүнтэй хээл авав. Мөн 2337 толгой бог малд зохимол хээлтүүлэг хийсэн. Нийт 9290 малд зохимол хээлтүүлгийн ажлыг хийсэн.</p> <ol style="list-style-type: none"> <li>2. 6 аймгийн ЗДТГ болон ХХААГ-аас "Махны, мах сүүний, сүүний үхрийн" аж ахуй эрхлэгч 11 аж ахуй нэгж, 26 иргэн, зөгийн аж ахуй эрхлэгч 8 иргэнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, 2-5 хүртлэх хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг олгосон байна.</li> <li>3. Увс, Дорнод аймгийн эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч, малчид, иргэдийн төлөөлөл 115 хүн Булган аймгийн Хутаг-Өндөр сумын "Занадуразербак" ХХК-ны мал бордох, мах үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай танилцсан. Мөн ХХААХҮЯамнаас олгосон махны чиглэлийн тус бүр нь 5.0 сая төгрөгийн үнэтэй Лимузин, Ангус үүлдрийн 4 толгой бухыг малчдад гэрээгээр олгож махны чиглэлийн үхэрт сайжруулагчаар үржилд ашиглаж байна.</li> <li>4. Дархан-Уул аймгийн ХХААГ-аас орон нутгийн малын чанар сайжруулах чиглэлээр малчдын хүсэлтээр ашиг шим өндөртэй малын үрээр 285 үхэрт хээлтүүлэг хийсэн. Мөн "Хонгор үржил" үржлийн нэгж 335 үхэр, "Мандах он" үржлийн нэгж 312 үхэрт тус тус зохиомолоор хээлтүүлэг хийж 81 хувийн хээл авалттай үр дүн гарсан. Орон нутагт 150 сая төгрөгийн өртөгтэй махны чиглэлийн 100 хээлтэгч худалдан авч нутагшуулсанаар цөм сүрэг бүрдлээ. Санамж бичгийн хүрээнд цөм сүргийн 100 гунж, Орхон сумын 185 үхрийг хээлтүүлэх 20,3 сая төгрөгийг зарцуулсан. Малын чанар сайжирч нэгж малаас авах ашиг шим нэмэгдэх юм.</li> </ol>	
<p>11 2.1.11. Бэлчээрийн мал аж ахуй эрхэлж байгаа өрхийг эдийн засгийн ашиг сонирхол дээр тулгуурласан малчдын бүлэг, хоршоо, нөхөрлөлийн хэлбэрээр хамтын аж ахуй эрхлэх эрх зүй, санхүү, эдийн засгийн нөхцөлийг бий болгон хөгжүүлэх;</p>	<p>2009 - 2020</p>			<ol style="list-style-type: none"> <li>1. Улсын хэмжээнд бүх сумдад малчдын бүлэг, фермер, хоршоо, нөхөрлөлийн хэв шинжит 4274 нь аж ахуй байна. 2020 оны жилийн эцсийн байдлаар шинээр 214 хоршоо байгуулагдаж нийт малчдын 68 хувь буюу 179.2 мянган малчин мал аж ахуй эрхлэх, хөдөлмөр, хүчээ хорших мэдлэг, дадлагаа нэмэгдүүлж, ахуй нөхцлөө сайжруулж байна. 2020 онд нийт 210 сая төгрөгийн зээлийн санхүүжилтийг хоршоодод олгосон байна.</li> </ol>	<p>90%</p>

12	2.1.12. Богд шилжүүлснээр бэлчээрийн 100 хүртэл малтай, зөвхөн түүнээс өрхийн орлого нь бүрдэж байгаа малчин өрхийн хөдөлмөрийн чадвартай гишүүдийг эдийн засгийн бусад салбарт шилжүүлэх, эсхүл малчдын бүлэг, хоршоо, нөхөрлөлд хамруулан ажлаар хангах бодлого хэрэгжүүлэх.	2009 - 2020			<ol style="list-style-type: none"> <li>1. Манай улсын ажил эрхэлдэг дөрвөн хүн тутмын нэг нь 2020 оны байдлаар мал аж ахуйн үйлдвэрлэлд ажиллаж байна. Тухайлбал, мал тооллогын 2020 оны урьдчилсан дүнгээр 298.8 мянган малчид мал аж ахуйн үйлдвэрлэлд ажиллаж байна. Малчдын тоо өмнөх оноос 13.3 мянган малчнаар буюу 4.7 хувиар өсжээ. Малтай нэг өрхөд ногдох малын тоо 2020 онд дунджаар 276 болж, өмнөх оноос 27 толгой мал буюу 8.9 хувиар буурсан байна. Малтай өрхийг малын тоогоор нь бүлэглэж үзэхэд 50 хүртэлх малтай өрх 7.4 хувиар, 51-200 хүртэлх малтай өрх 13.1 хувиар өссөн.</li> <li>2. МУ-н ЗГ-ын 34 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол малчин” үндэсний хөтөлбөр болон Хөдөлмөр халамж үйлчилгээний Ерөнхий газраас зохион байгуулалттай ажлын байр туршилтын төсөл хэрэгжүүлсэн. Энэхүү хөтөлбөр арга хэмжээний хүрээнд хот, суурингаас хөдөөд шилжин суурьшиж, мал маллах хүсэлтэй гэр бүл болон туслах малчинг цалин хөлстэй ажилд зуучилж, тогтвортой ажлын байр, орлоготой болгоход чиглэгдсэн юм. Улмаар энэ оны эхний улирлын байдлаар нийт 627 иргэн хамрагдаж 108,002.7 мянган төгрөг зарцуулж 547 ажлын байр бий болсон байна. Тодруулбал, Сумын ажилгүй иргэдийг бүлгийн зохион байгуулалттайгаар хөдөлмөр эрхлүүлэх арга хэмжээнд 21 аймгийн 84 бүлгийн 421 иргэд хамрагдаж 87,003.2 мянган төгрөгийг; Хорооны ажилгүй иргэдийг багийн зохион байгуулалттайгаар хөдөлмөр эрхлүүлэх арга хэмжээнд 9 дүүргийн 56 багийн 537 иргэд хамрагдаж 40,475.8 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.</li> <li>3. Өрхийн аж ахуй, бичил бизнес эрхлэгчдийг өртөг шингэсэн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны 1 дүгээр тогтоолоор баталсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн хүрээнд 10.0 хүртэл сая төгрөгийн итгэлийн зээл буюу санхүүгийн дэмжлэгийг 24-48 сарын хугацаанд 100 хувь эргэн төлөх нөхцөлтэйгээр олгох арга хэмжээг улсын хэмжээнд хэрэгжүүлж байна.</li> </ol>	100%
2.2. Малчин өрхийн эдийн засгийн үндэс болсон мал аж ахуйн үйлдвэрлэлийн зохион байгуулалтыг сайжруулж бүтээмж, чанар, үр ашгийг дээшлүүлэх, бүтээгдэхүүн борлуулах зах зээлийн оновчтой тогтолцоо бий болгох бодлогын чиглэлийн хүрээнд дараахь стратегийн зорилт дэвшүүлэн хэрэгжүүлнэ:						
13	2.2.1. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд бизнес, санхүү, зээл, хууль зүйн туслалцаа үзүүлэх,	2009 - 2020			<ol style="list-style-type: none"> <li>1. ЖДҮХС нь 2020 онд Улаанбаатар хот болон 21 аймагт нийт 1429 иргэн, 1318 аж ахуйн нэгжийн 487,196.3 сая төгрөгийн зээлийн хүсэлтийг хүлээн авч, цахим системд бүртгэснээс Улаанбаатар, орон</li> </ol>	100%

	<p>мал эмнэлэг, үржлийн болон хөдөө аж ахуйн шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлэх үйлчилгээг орон нутагт хөгжүүлж, чанарыг сайжруулах;</p>			<p>нутгаас нийт 249 төсөлд нийт 22.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлсэн байна. Үүнээс эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр Улаанбаатар хотод 13 төсөл, орон нутагт 28 төслийг сонгон шалгаруулж 3.9 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна. Хөнгөлөлттэй зээлийн дэмжлэгт хамрагдсан эрчимжсэн мал аж ахуй эрхлэх нийт 41 төслийн 85 хувь буюу 35 төсөл үйл ажиллагаагаа өргөжүүлж, 15 хувь буюу 6 төсөл шинээр үйл ажиллагааг эхлүүлж, нийт 98 ажлын байр хадгалагдан үлдэж, 198 ажлын байр шинээр бий болгохоор төлөвлөсөн. Эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр санхүүжилт авсан нийт төслийн 51.22% нь сүүний үхэр, 29.27% нь махны үхэр, 14.63% хувь нь мах, сүүний хосолсон чиглэлээр, 4.88% нь зөгийн аж ахуйн чиглэлээр тус тус үйл ажиллагааг явуулж байна. Үүнээс шувууны аж ахуй эрхлэх чиглэлээр ЖДҮХС-аас Улаанбаатар хотод 2 төсөл, орон нутагт 5 төслийг сонгон шалгаруулж нийт 1.3 тэрбум төгрөгийн урт хугацаатай, хөнгөлөлттэй зээлийг олгосон.</p> <ol style="list-style-type: none"> <li>2. 2020 онд улсын төсвийн 430.0 сая төгрөгийн хөрөнгөөр хийгдсэн малын үзлэг ангилалтын ажлыг 59 мал үржүүлэг технологийн нэгжтэй гэрээ байгуулж гүйцэтгүүлэв.</li> <li>3. Мөн орон нутгийн төсвийн 216.0 сая төгрөгийн санхүүжилтээр Архангай, Өвөрхангай, Дундговь, Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгийн 13 мэргэжлийн нэгжид зоо багаж хэрэгсэл, үржлийн мал нийлүүлэх тендер сонгон шалгаруулалтыг орон нутгийн мэргэжлийн байгууллага зохион байгуулж хэрэгжүүлэв.</li> <li>4. 2020 онд 30 нэгж шинээр байгуулагдаж, улсын хэмжээнд Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний 131 нэгж тогтмол үйл ажиллагаа явуулж байна.</li> </ol>	
14	<p>2.2.2. Малчдын өөрсдийнх нь санал болгосон хүнийг тусгайлан сургах замаар малчдын бүлэг, хоршоо, нөхөрлөлийн удирдлагыг бэлтгэх арга хэмжээг төрөөс санаачлан хэрэгжүүлэх, орон нутгийн удирдлага, багийн Засаг дарга нарт энэ чиглэлээр сургалт зохион байгуулах;</p>	2009 - 2020		<ol style="list-style-type: none"> <li>1. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас цар тахал хэмээн албан ёсоор хүлээн зөвшөөрч тодорхойлсон коронавирусийн өвчлөл, хорио цээрийн дэглэмтэй холбогдуулан Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо Удирдах зөвлөлийн III хурлыг 2020 оны 04-р сарын 16-нд өдөр цахимаар санал авч хуралдав. Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо нь “ХАА-н хөгжлийг дэмжих олон улсын сан”/IFAD/-ийн Монгол Улсыг хариуцсан захирал Үберт Бойрард-тай хамтын ажиллагааны Санамж бичиг 2020 оны 01-р сарын 27-ны өдөр байгуулж гарын үсэг зурсан. Санамж бичгийн хүрээнд “Зах зээл ба бэлчээрийн</li> </ol>	100%

				<p>удирдлагын хөгжил” төслийн нэмэлт санхүүжилтээр Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Өвөрхангай, Дундговь, Архангай, Говь-Алтай Хөвсгөл, Булган зэрэг төслийн зорилтот аймгуудын орон нутгийн бага дунд орлоготой иргэдийн орлогыг бодитоор нэмэгдүүлэн тэдгээрийн амьжиргааг тогтвортой болгох зорилгоор Үндэсний холбоо гишүүн хоршооддоо чадавхийн үнэлгээ хийх, 4P бизнес төлөвлөгөө боловсруулах ажлыг 9 аймгийн 25 суманд зохион байгуулан ажилласан байна.</p> <p>2. Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас хэрэгжүүлж буй “Малчдын нийгмийн хамгааллыг өргөжүүлж, цочролд бэлэн байх чадавхийг нэмэгдүүлэх нь” төсөл нь 2020 оны 07-р сараас 2021 оны 12 сар хүртэлх хугацаанд Завхан аймагт хэрэгжинэ.</p> <p>3. Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо, Хөдөөгийн тогтвортой хөгжлийн төлөөх Азийн фермерүүдийн холбоо /АФХ/-той хамтран “Хоршооллын салбар дах залуучуудын манлайлал, нөлөөлөл” сэдэвт сургалтыг 2020 оны 06-р сарын 25-28-ны өдрүүдэд Үндэсний холбооны хурлын танхимд зохион байгуулсан.</p> <p>4. Дундговь аймгийн ЗДТГ, НҮБ-ын Аж үйлдвэр хөгжлийн байгууллагатай хэрэгжүүлж буй “Аймгийн хөнгөн болон хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх” хамтын ажиллагааны хүрээнд “Хонины ноосны чанарыг сайжруулах” олон улсын сургалтыг 2020 оны 06-р сарын 29-нөөс 07-р сарын 05-ны өдрүүдэд Сайнцагаан суманд амжилттай зохион байгуулагдлаа.</p>	
15	2.2.3. Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулж, гарал үүслийг тодорхой болгон нэмүү өртөг бүхий бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг бий болгох замаар малчдын орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн "Мах үйлдвэрлэл", "Сүү үйлдвэрлэл", "Арьс, шир бэлтгэл", "Ноос, ноолуур бэлтгэл" зэрэг хөтөлбөрүүд хэрэгжүүлэх;	2009 - 2020		<p>1. ЗГ-ын 2018 оны 47 дугаар тогтоолоор "Ноолуур" хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байна. Малчид, үндэсний үйлдвэрийг дэмжих зорилгоор хонь, тэмээний ноос, арьс шир, сүүг стандартын дагуу бэлтгэж үндэсний үйлдвэрт тушаасан малчин, мал бүхий этгээдэд ЗГ-ын 2013 оны 394, 2019 оны 343, 2020 оны 130 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу урамшуулал олгож байна.</p> <p>2. Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулж, гарал үүслийг тодорхой болгон нэмүү өртөг бүхий бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг бий болгоход дэмжих зорилгоор 2 стандартыг боловсруулав. ТНБД-ын А-69 тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг нь мал, амьтны тавлаг байдлын таван эрх чөлөөг хангах, мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэх, бэлчээрийн мал аж ахуйн анхан шатны үйлдвэрлэгчийн түвшинд</p>	100%

					<p>хариуцлагатай нүүдэлчин тогтолцоог хэрэгжүүлэхэд баримтлах үндсэн зарчим, шаардлага, шалгууруудыг тогтоох, тэдгээрийг үнэлэх, баталгаажуулах зорилгоор "MNS 2020 Хариуцлагатай нүүдэлчин зохистой дадлыг нэвтрүүлэхэд тавигдах шаардлагууд" стандартын төслийг боловсруулсан. Зохистой дадал нэвтрүүлсэн бэлчээрийн мал аж ахуйгаас бэлтгэсэн түүхий эдийг байгальд ээлтэй технологиор боловсруулж нэмүү өртгийн сүлжээний хүрээнд үр өгөөж, үүрэг хариуцлагыг тэгш хуваарилах зарчмыг баримтлан ил тод, тасралтгүй, ёс зүйтэй үйлдвэрлэл эрхлэх үйл ажиллагаанд баримтлах үндсэн зарчим, шаардлагуудыг тогтоох, тэдгээрийг үнэлэх, баталгаажуулах зорилгоор MNS "Текстилийн тогтвортой үйлдвэрлэлд тавигдах шаардлагууд" стандартын төслийг боловсруулсан.</p> <p>3. 2020.09.30-ны өдрийн ЗГ-ын 130 дугаар тогтоолоор “Сүү боловсруулах үйлдвэр, цехэд гарал үүсэл нь баталгаажсан эрүүл малыг, техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн түүхий сүүг нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшуулал олгох” журмыг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үйлдвэрийн аргаар боловсруулсан сүү, сүүн бүтээгдэхүүний хэмжээ 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр 186,5 сая.литр хүрч 11.3 %-иар нэмэгдсэн.</p>	
16	2.2.4. Бүтээгдэхүүнийг боловсруулах, борлуулах зах зээлийн тогтолцоог бүс нутгийн онцлогт нийцүүлэн бий болгож хөгжүүлэх;	2009 - 2020			<p>1. Боловсруулах үйлдвэрүүдийг чанар, стандартын шаардлага хангасан түүхий эдээр хангах, малчдын орлого, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор зарим суманд мал аж ахуйн гаралтай түүхий эдийг бэлтгэх, тээвэрлэх, хадгалах нэгдсэн бүтэц бүхий загвар хоршоо байгуулж, кластерын тогтолцоог бүсчлэн хөгжүүлэх арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх ажлын хүрээнд Архангай аймгийн Өндөр-Улаан сумын “Малчин түмний буян” хоршоог чадавхижуулах, загвар хоршоо болгон хөгжүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг зохион байгуулав. Үүнд: 1) Богийн арьсыг халимлах машин; 2) Төсөлд хамрагдах АА-н нэгжүүдэд түүхий эд нийлүүлдэг сумын төвийн ноосны хоршоодыг чадавхижуулах; 3) Тордолтын цехэд шаардлагатай химийн бодис нийлүүлэх; Харин түүхий эдийн агуулах барих болон инженерийн хийцтэй гүнийн худаг гаргахад шаардагдах газрын зөвшөөрөл, хайгуул болон зураг төслийн ажил хийгдээгүй байгаа тул эдгээр ажлыг хийж гүйцэтгэхээр ажиллаж байна.</p>	70%

					<ol style="list-style-type: none"> <li>2. Бүтээгдэхүүнийг боловсруулах, борлуулах зах зээлийн тогтолцоог бүс нутгийн онцлогт нийцүүлэн хөгжүүлэх чиглэлээр хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэнгийн эрдэмтэд, механик цехийн инженерүүд орон нутагт эко технологиор малын гаралтай түүхий эдийг боловсруулах технологи болон тоног төхөөрөмж ашиглах практик сургалтыг зохион байгуулж, түүхий эдийн нөөцөд тохирсон тоног төхөөрөмжийг зохион бүтээж нийлүүлсэн.</li> <li>3. Увс аймгийн Ховд сум ЖДҮХСангаас арьс боловсруулах тоног төхөөрөмжүүдийг 20%-ийн урьдчилгаа төлж, 5 жилийн хугацаатай, хүүгүй хөнгөлөлттэй нөхцөлөөр олгосон.</li> <li>4. Сүүний хувьд үйлдвэрийн аргаар боловсруулсан сүү, сүүн бүтээгдэхүүний хэмжээ 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр 186,5 сая.литр хүрч нийт үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүний эзлэх хувь 18 болсон. Махны хувьд 2020 оны 11 дүгээр сарын байдлаар үйлдвэрийн аргаар боловсруулсан махны хэмжээ 20.3 мянган тн, өмнөх онтой харьцуулахад 77.8 хувийн гүйцэтгэлтэй байна.</li> </ol>	
17	2.2.5. Малын гаралтай түүхий эд (арьс, шир, ноос, ноолуур, өлөн гэдэс, эвэр, туурай, яс, хялгас зэрэг)-ийг худалдан авах, түүнд чанарын анхан шатны ангилалт, боловсруулалт хийх цех, нэгжийг малчдын оролцоо бүхий малчдын бүлэг, хоршоо, нөхөрлөлийн хэлбэрээр сум бүрт бий болгох, бүсүүдэд жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх;	2009 - 2020			<ol style="list-style-type: none"> <li>1. Сум бүрт тухайн орон нутагт эрхэлж явуулах хамгийн өргөн боломжтой үйлдвэрлэл, бэлтгэн нийлүүлэлт, үйлчилгээнд түшиглэсэн загвар хоршоо бий болгох нь тухайн хоршооны хөгжил гишүүддээ үзүүлэх үйлчилгээ дэмжлэгийг сайжруулаад зогсохгүй сумын нийгэм, эдийн засагт үзүүлэх эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх өндөр ач холбогдолтой Загвар хоршооны ТЭЗҮ-г боловсруулав.</li> <li>2. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2020 онд 10 хоршоонд 586,0 сая төгрөгийн зээл олгосоноос Архангай аймгийн "Хан дулаан хан"хоршоо, Улаанбаатар хотын "Цахир дэл" хоршоод малын дайвар бүтээгдэхүүн боловсруулах чиглэлээр 199,7 сая төгрөгийн санхүүжилт авсан. Төслийн үр дүнд шинэ ажлын байр 5 бий болж, 4 хадгалагдана.</li> <li>3. Азийн хөгжлийн банкны “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт” төслийн хүрээнд 906.3 сая төгрөгийн өртөгтэй арьс шир халимлах машин, сүүний чиглэлийн хоршоодод сүү боловсруулах иж бүрдэл, ноосны хоршоог чадавхижуулах багаж, хэрэгсэл болон зөгийн салбарын хоршоодод зөгийн гэр, сэмж нийлүүлээд байна. Боловсруулах үйлдвэрүүдийг чанар, стандартын шаардлага хангасан түүхий эдээр хангах, малчдын орлого, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор мал аж ахуйн гаралтай түүхий эдийг</li> </ol>	100%



				<p>бэлтгэх, тээвэрлэх, хадгалах нэгдсэн бүтэц бүхий загвар хоршоог Архангай аймгийн Өндөр-Улаан суманд байгуулав.</p> <p>4. Малчид, түүхий эд бэлтгэлийн төлөөлөгч, орон нутгийн мэргэжилтэн, үйлдвэрлэл эрхлэгч зэрэг түүхий эд бэлтгэлд оролцож буй оролцогч талуудыг чадавхижуулах ажлын хүрээнд дараах сургалтуудыг зохион байгуулав. “Түүхий эдэд тордолт хийх, түүхий эд бэлтгэлийн тогтолцоог боловсронгуй болгоход шаардагдах технологийн сургалт”-ыг Архангай, Баянхонгор, Завхан, Хөвсгөл, Хэнтий, Сүхбаатар, Нийслэлд мал нядалгааны цех, түүхий эд бэлтгэлийн төлөөлөгч, малчдад сургалт явуулав. “Хонины ноосны чанарыг сайжруулах” олон улсын сургалтыг 6 дугаар сард Дундговь аймагт зохион байгуулав. Сумдын хоршооны гишүүн 40 гаруй гишүүд хамрагдаж хяргагч, ноос ангилан ялгагчаар бэлтгэгдэв.</p>	
18	2.2.6. Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэл, чанарын стандарт, түүнийг хэрэглэх заавар, журмыг шинэчлэн боловсруулж, мөрдүүлэх;	2009 - 2020		<p>1. Арьс, ширэн түүхий эдийн нядалгааны үеийн бэлтгэл, чанарыг дээшлүүлэх ажлын хүрээнд Малын арьс ширийг өвчих, хуулахад тавих ерөнхий шаардлага MNS 6870:2020 стандарт батлагдав. Сумдад малын гаралтай түүхий эдийг бэлтгэх, хүлээн авах, стандартын дагуу ангилан ялгалт болон чанарын хамгаалалт хийж, зориулалтын дагуу хадгалах, тээвэрлэх, борлуулах сүлжээг хоршоодод тулгуурлан бий болгох ажлын хүрээнд: Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймаг, 330 сумдын салбар хариуцсан мэргэжилтнүүдийг цахим сургалтанд хамруулж тэднийг мэдээллээр хангаж, чадавхижуулав.</p> <p>2. Мөн “Түүхий эдэд тордолт хийх, түүхий эд бэлтгэлийн тогтолцоог боловсронгуй болгоход шаардагдах технологийн сургалт”-ыг Архангай, Баянхонгор, Завхан, Хөвсгөл, Хэнтий, Сүхбаатар, Нийслэлд мал нядалгааны цех, түүхий эд бэлтгэлийн төлөөлөгч, малчдад сургалт явуулав. “Хонины ноосны чанарыг сайжруулах” ОУ-ын сургалтыг Дундговь аймагт зохион байгуулав. Сургалтанд сумдын хоршооны гишүүн 40 гаруй гишүүд хамрагдаж хяргагч, ноос ангилан ялгагчаар бэлтгэгдэв.</p> <p>3. Арьс ширний нядалгааны үеийн гэмтлийг бууруулах зорилготой арьс шир хуулах төхөөрөмж дээр ажиллах практик сургалтыг Ховд, Баянхонгор аймгуудад зохион байгуулав."ХХААХҮ-ийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих урамшуулал олгох журам"-ыг боловсруулж ЗГХЭГ-т хүргүүлэв.</p>	90%

					4. Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалтын төслийг ХХААХҮ-ийн сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалтын төсөлд малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэл, чанарын стандарт зэрэг асуудлууд тусгагдсан байна. Тухайн төслийг холбогдох хууль тогтоомжийн дагуу боловсруулж ХХААХҮ-ийн сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. Мөн төслийг мал төхөөрөх үйлдвэрийн удирдлагуудад цахим хэлбэрээр танилцуулав.	
19	2.2.7. Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зорилгоор төсвийн хөрөнгөөр усны хайгуул хийх, инженерийн хийцтэй худаг гаргах, засварлахын зэрэгцээ малчдын үүсгэл, санаачилгаар худаг гаргах, засварлах, цас, борооны ус тогтоох, усан сан, нуур, цөөрөм байгуулахыг төрөөс урамшуулан дэмжих;	2009 - 2020			<ol style="list-style-type: none"> <li>2020 онд Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор 21 аймгийн 193 сумдад улсын төсвийн 1.67 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 83, гадаадын төсөл, хөтөлбөрийн 3.7 тэрбум төгрөгөөр 180, орон нутгийн төсвийн 3.7 тэрбум төгрөгөөр 287 инженерийн хийцтэй худаг, малчдын өөрсдийн санаачлагаар 170 гар худаг, нийт 9.0 тэрбум төгрөгөөр 550 инженерийн хийцтэй худаг гаргасан нь 825.0 мянган га бэлчээр, 2.7 мянган малчин өрхийн 1.7 сая толгой малын усан хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээ болсон. Орон нутаг болон төсөл хөтөлбөрийн 1.8 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 15 аймагт 184 худаг сэргээн засварлах, 11 аймагт 126 булаг тохижуулах, 5 аймагт 9 хөв цөөрөм, Өвөрхангай аймагт 2 худаг шинээр гаргаж сэргээгдэх эрчим хүчээр ажиллах ус өргүүр суурилах ажил хийж ашиглалтанд оруулсан.</li> <li>2020 онд Улсын төсвийн 250.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Завхан, Увс, Төв, Хөвсгөл аймгийн 200 бэлчээрийн газарт “Энхсүлд”ХХК, “Ус-Амьдрал”ХХК, “Монкаротаж”ХХК, “Эрдэнэдрилинг”ХХК-ууд газрын доорх усны геофизикийн хайгуулын ажил хийх гэрээ байгуулснаас 7 аймгийн 51 сумын 209 бэлчээрийн газарт хайгуулын ажил хийж устай цэг 167 заасан нь устай байх магадлал 83 хувь байна.</li> </ol>	100%
20	2.2.8. Малчдын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор худаг ус гаргах, тэжээл бэлтгэх зэрэг мал аж ахуйн үйлдвэрлэлд шаардлагатай олон нийтийг хамарсан арга хэмжээг түлхүү зохион байгуулах;	2009 - 2020			<ol style="list-style-type: none"> <li>2020 оны 12 дугаар сарын 04-ны өдрөөс 2021 оны 07 дугаар сарын 01-ний хооронд бүх төрлийн тэжээлийн үрийн импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварыг тэглэж аж ахуй нэгжүүдийн тэжээлийн ургамлын үр импортлох боломжийг бүрдүүлсэн. Энэ хүрээнд аж ахуй нэгжтэй тэжээлийн үр импортлох бодлогын гэрээ байгуулан ажиллаж байна.</li> <li>Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд тэжээл тариалах зориулалтаар газар ашиглуулах талаар санаачлага гарган ажиллах талаар</li> </ol>	100%

					<p>ХХААХҮ-ийн сайдын баталсан удирдамжийг аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газруудад хүргүүлсэн. Уг удирдамжийн дагуу Сэлэнгэ, Төв, Говьсүмбэр, Хэнтий аймгууд тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор батлуулан ажиллаж байна. Энэ ажлын үр дүнд 2020 онд хураан авсан таримал тэжээлийн хэмжээ өмнөх оныхоос 61.0 мянган тонн буюу 50.3 хувиар нэмэгдсэн.</p> <p>3. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд малын тэжээл тариалах зориулалтаар сум бүрт 10 га газар ашиглуулах тухай Архангай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол гарган хэрэгжүүлж ажиллажээ.</p> <p>4. “Бэлчээр хамгааллын арга хэмжээг эрчимжүүлэх тухай” Засгийн газрын 2019 оны 185 дугаар тогтоолоор жил бүрийн 5 дугаар сарын эхний долоо хоног болон 10 дугаар сарын сүүлийн 7 хоногийн Баасан, Бямба, Ням гарагийг “Бэлчээр хамгаалах өдөр” болгон зарлаж, мэрэгч амьтан, шавжны хөнөөлөөс бэлчээрээ хамгаалах бүх нийтийн арга хэмжээг сум, багийн түвшинд зохион байгуулж байхыг аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосон. Ингэснээр бэлчээр ашиглалт, хамгааллын арга хэмжээг орон нутагт зохион байгуулж тайлагнадаг жишиг тогтоод байна. Тухайлбал 2020 онд үлийн цагаан оготнотой тэмцэх арга хэмжээнд зарцуулах орон нутгийн төсвийн хөрөнгө 750 орчим сая төгрөгөөр нэмэгдсэн. Орон нутгийн төсвийн хөрөнгөд аймаг, сумдын төсвөөс 1.2 тэрбум, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн түр ажлын байрны зардлаас 112.0 сая төгрөг тус тус зарцуулагдсан. Уг арга хэмжээнд урьдчилсан байдлаар 17 аймгийн 184 сумын 400 гаруй багт нийт 7000 орчим хүн ажилласан байна.</p>	
21	2.2.9. Шилжин суурьшсан малчин байсан иргэдийг хот төлөвлөлтийн бодлоготой уялдуулан нийгмийн үйлчилгээнд хамруулах, ажлын байраар хангах бодлого хэрэгжүүлэх;	2009 - 2020			<p>1. ХХҮЕГ-ын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ болон хувийн хөдөлмөрийн биржүүдийн хүрээнд 2020 оны ажлын байрны захиалгын мэдээгээр 71.1 мянган ажлын байр нээлттэй зарлагдсан нь өмнөх оны мөн үеэс 10.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Ажлын байрны захиалга Төвийн бүсэд 46.5 хувь, Баруун бүсэд 5.1 хувиар тус тус өссөн бол Хангайн бүсэд 11.6 хувиар буурч, зүүн бүсэд хэвээр байна. 2020 онд нийт ажлын байрны захиалгын 34.8 хувийг үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарын ажлын байр, 13.6 хувийг уул уурхай, олборлолтын ажлын байрны захиалга эзэлж байна. 2020 оны нийт 71.1 мянган ажлын байрны захиалгын 12,3</p>	90%

					<p>хувь буюу 8,7 мянган малчин байсан иргэн ажлын байранд зуучлагджээ.</p> <p>2. Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилтээр “Ногоон-алт” төсөл Дашинчилэн, Могод, Хишиг-Өндөр, Орхон сумдад хэрэгжиж байна. Могод суманд 8, Дашинчилэн суманд 7, Орхон суманд 7, Хишиг-Өндөр суманд 5, нийт 27 бэлчээр ашиглагчдын хэсэг албан ёсоор байгуулагдсан. Дунджаар 1 БАХ 20-30 малчдаас бүрдэж байна. Дээрх 4 суманд дундын сан байгуулагдсан. Орхон сум 10.0 сая, Дашинчилэн 40.0 сая, Могод 8.0 сая, Хишиг-Өндөр 5.0 сая төгрөгийн дундын сантай байна.</p>	
22	2.2.10. "Малчдын орон сууц", "Монгол гэр" хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх;	2009 - 2020			<p>1. Малчдыг мэдээллээр хангах, хөгжүүлэх, орон нутагтаа ая тухтай ажиллах, амьдрах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах, бүтээмж, орлого, ашгийг нь өсгөх, тэдгээрийг чадавхжуулах зорилгоор МУ-ын ЗГ-ын 2020 оны 34 дүгээр тогтоолоор "Монгол малчин" үндэсний хөтөлбөрийг 2020-2024 онд хэрэгжүүлэхээр батлав.</p> <p>2. Мөн МУ-ын ЗГ-ын 2019 оны 202 дугаар тогтоолоор "150 мянган айл-Орон сууц" үндэсний хөтөлбөрийг баталсан бөгөөд хөтөлбөрийн 4.4.4.-д малчдын орон нутагтаа тав тухтай ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, тэдний нүүдэлчин ахуй нөхцөлд тохирсон, байгаль орчинд ээлтэй, ус, дулаан, эрчим хүчний хэмнэлттэй орон сууцтай болоход нь санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд авч хэрэгжүүлэх; гэсэн заалтыг тусгуулав.</p>	70%
23	2.2.11. Малчин өрх бүрийг 2015 он гэхэд 100 хувь радиотой болгох, цахилгааны эх үүсвэртэй болгох хөтөлбөрийг үргэлжлүүлэх, малчдад цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээ болон зах зээлийн мэдээллийг гар утсаар хүргэх нөхцөлийг бүрдүүлэх;	2009 - 2020			<p>1. 2020 оны байдлаар 147.9 мянган малчин өрх цахилгааны эх үүсвэртэй, 277.5 мянган малчин өрх гар утастай, 66.6 мянган малчин өрх интернэтэд холбогдох боломжтой байгаа тул цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээ болон зах зээлийн мэдээллийг цаг алдалгүй авч байна.</p>	100%
24	2.2.12. Малчдыг байгалийн гамшгийн үед өмсөхөд зориулсан дулаан, тохиромжтой хувцсаар хангах,	2009 - 2020			<p>1. Монгол дээлийг инновацийн бүтээгдэхүүн болгож буй “Хадлан” дээлийн загварыг сурталчлан танилцуулж, гадаад дотоодын зах зээлд үйлдвэрлэн гаргаж байна.</p>	50%

	энэ чиглэлээр дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх;					
25	2.2.13. Бүс нутаг, аймгийн түвшинд хөдөө аж ахуйн машин, техник нийлүүлэх, лизинг, засвар үйлчилгээ, сэлбэгээр хангах тогтолцоо бий болгох, техник ашиглалтын сургалт, үзүүлэх сургууль зохион байгуулж байх;	2009 - 2020			1. Хувийн хэвшлийн оролцоотойгоор бүс нутаг, аймгийн түвшинд хөдөө аж ахуйн машин, техник нийлүүлэх, лизинг, засвар үйлчилгээ, сэлбэгээр хангах тогтолцоо бий болсон. Мөн техник ашиглалтын сургалт, үзүүлэх сургууль зохион байгуулагдаж байна.	100%
26	2.2.14. Өвс, тэжээлийн чанар, сав, баглаа боодлын стандартыг шинэчлэн тогтоож шинэ технологи нэвтрүүлэн овор багатай, чанар сайтай тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх;	2009 - 2020			1. Таримал ногоон тэжээлийн техникийн шаардлага MNS 6788 : 2019 стандартыг батлуулсан. 2019 онтой харьцуулахад тэжээл үйлдвэрлэлийн хэмжээ улсын хэмжээнд 8,6-иар өссөн дүнтэй байна. Мөн ХХААХҮ-ийн сайдын 2021 оны А-29 дугаар тушаалаар “Мал, амьтанд зориулан үйлдвэрлэх, импортлох тэжээлийн аюулгүй байдалд тавих шаардлага”-ыг баталгаажуулаад байна.	100%
27	2.2.15. Тэжээлийн нөөцийн хэмжээ, хүртээмж, байршлыг оновчтой тогтоох, түүний хадгалалт, хамгаалалт, зарцуулалтын менежментийг сайжруулах, сум, багийн түвшинд өвс, тэжээл худалдаалах байнгын цэг, нэгдсэн сүлжээ бий болгох;	2009 - 2020			1. Улсын хэмжээнд 119 тэжээлийн үйлдвэр, цех байгаагаас 71 нь байнгын болон түр ажиллагаатай, 48 нь огт ажиллагаагүй байна. Монгол Улсын хувьд малын тэжээлээр дагнасан тэжээл үйлдвэрлэдэг нийт 32 аж ахуйн нэгж, цехүүд байна. Үүнээс томоохон 7 аж ахуйн нэгж байгаагаас Улаанбаатар хотод 5, Сэлэнгэ аймагт 1, Дорнод аймагт 1 байна. Нийт тэжээлийн үйлдвэр, цехүүдээс улирлын чанартай 9, байнгын үйл ажиллагаа явуулдаг 23 байна. Монгол улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй нийт үйлдвэрийн нийлбэр хүчин чадал нь жилд 193.6 мянган тонн тэжээл үйлдвэрлэх хүчин чадалтай байна. Нийт хүчин чадлынхаа 38.4%-д тэжээл үйлдвэрлэж байна. 2. Хөдөө аж ахуйн салбарын 2020-2021 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай засгийн газрын 19 дүгээр тогтоолоор цаг агаар хүндэрсэн үед ашиглах өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэлтийн тогтолцоонд дараах өөрчлөлтийг оруулсан. Үүнд: - Улс, аймгийн аюулгүйн нөөцөд хадлан бэлтгэхгүй байх - Бэлтгэвэл зохих өвс, тэжээлийн хэмжээг малын тооны өсөлттэй уялдуулан нэмэгдүүлсэн Дээрх өөрчлөлтийн үр дүнд малчдын гар дээр очих хадлангийн хэмжээ нэмэгдэж малчид Засгийн газрын тогтоолоор өгөгдсөн өвсний 80 хувийг бүрдүүлсэн.	100%

					<p>3. Түүнчлэн зах зээл дээрх тэжээлийн олдоц хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор бүх төрлийн малын тэжээлийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэл чөлөөлөх бодлогын дэмжлэг үзүүлсэн.</p> <p>4. Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн /нэмэлт санхүүжилт/ хөрөнгө оруулалтаар Дундговь, Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгуудын 11 суманд тэжээлийн агуулах, саравчийг барьж ашиглалтанд оруулаад байна.</p>	
28	2.2.16. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон тэжээлийн ургамлын улсын үрийн нөөцтэй болж нутагшсан сортын үрийг баталгаажуулж, түүнийг тариалах ажлыг өргөжүүлэх, уургийн агууламж өндөртэй тэжээлийн ургамлын тариаланг нэмэгдүүлэх;	2009 - 2020			<p>1. Эрдэм шинжилгээний байгууллагууд шинжлэх ухаан технологийн төслийн санал боловсруулж хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын дэргэдэх шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ажилласан. Уг зөвлөлийн хурлаар дэмжсэн төслийн саналыг Шинжлэх ухаан, технологийн санд уламжлан хүргүүлсэн. Үүний үр дүнд Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнд "малын тэжээлийн элит болон сортын үр үйлдвэрлэх технологи" сэдэвт 90 сая төгрөгийн санхүүжилттэй төслийг 2020-2022 онд хэрэгжүүлэх гэрээ байгуулан ажиллаж байна.</p> <p>2. Эрчимжсэн аж ахуйн тэжээлийн үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор "Уурагт таримал тэжээл тариалж тэжээлийн нөөц нэмэгдүүлэх" төсөл зарлан 17 аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж, 1.0 тэрбум төгрөгийн зээл олгосноор 2018 онд тэжээлийн ургамал тариалалт 1000 га-гаар нэмэгдсэн.</p> <p>3. Малчид, мал аж ахуй эрхлэгчдэд тэжээлийн ургамал тариалахад шаардлагатай үрээр хангах зорилгоор гадаадаас үр худалдан авах санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх талаар талт уулзалтуудыг хийж ажиллаж байна. Үүний үр дүнд хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангийн санхүүжилттэйгээр тэжээлийн ургамлын үр худалдан авах арга хэмжээг 2021 онд хэрэгжүүлж малчид, иргэд, аж ахуй нэгжүүдэд үр үржүүлэх боломжоор хангахаар ажиллаж байна.</p> <p>4. 2020 оны 12 дугаар сарын 04-ны өдрөөс 2021 оны 07 дугаар сарын 01-ний хооронд бүх төрлийн тэжээлийн үрийн импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварыг тэглэж аж ахуй нэгжүүдийн тэжээлийн ургамлын үр импортлох боломжийг бүрдүүлсэн. Энэ хүрээнд аж ахуй нэгжтэй тэжээлийн үр импортлох бодлогын гэрээ байгуулан ажиллаж байна.</p>	100%

29	2.2.17. Малын хашаа, дулаан байрны зураг төсөл гаргаж материалын нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх, энэ чиглэлээр шинэ технологи нэвтрүүлэх, шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх;	2009 - 2020			<ol style="list-style-type: none"> <li>1. Малын хашаа, дулаан байрны зураг төсөл гаргаж материалын нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх, энэ чиглэлээр шинэ технологи нэвтрүүлэх, шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд ХХААХҮЯ-ны захиалгаар 2021-2023 онд хэрэгжүүлэх “Бэлчээрийн мал аж ахуйн үйлдвэрлэлийн хүнд хүчир хөдөлмөрийг хөнгөвчилж бүтээмжийг дээшлүүлэх, малчдын хөдөлмөр, ахуйн нөхцөлийг сайжруулах судалгаа, хөгжүүлэлт” сэдэвт Шинжлэх ухаан, технологийн төслийн саналыг БСШУСЯ-д 2020 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 01/940 тоот албан бичгээр хүргүүлэв.</li> <li>2. Мөн малын хашаа, дулаан байрны загвар зураг төсөл 2-ыг гаргаж, материалын нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх, шинэ технологи нэвтрүүлэх чиглэлээр нэг төсөл хэрэгжүүлсэн.</li> </ol>	70%
30	2.2.18. Мал аж ахуйн хүнд хүчир хөдөлмөрийг хөнгөвчилж хөдөлмөр зохион байгуулалтыг сайжруулах, дэвшилтэт технологи нэвтрүүлэх;	2009 – 2020			<ol style="list-style-type: none"> <li>1. Малчдын хамтын хоршил, санаачилгыг дэмжих, малчдыг чадавхижуулах, тэдгээрийн орлогыг нэмэгдүүлэх зорилго бүхий арга хэмжээг олон талт хөгжлийн байгууллагуудын санхүүжилтийн хүрээнд хэрэгжүүлж байгаа техник тусламцааны 8 төсөл, хөнгөлттэй зээлийн 2 төсөл, буцалтгүй тусламжийн 6 төслийн хүрээнд 3,6 тэрбум төгрөгийн санхүүжилтээр бага оврын трактор, хадуур, тармуур, сүү хадгалах сав, бага оврын саалтуур, цагаан идээ боловсруулах төхөөрөмжийг олгосон байна.</li> </ol>	90%
31	2.2.19. Аймаг, сумын түвшинд арвин ашиг шимтэй мал, амьтан бойжуулж, борлуулах үржлийн аж ахуйг бий болгон хөгжүүлэх, тухайн орон нутгийн малын чанарыг сайжруулах арга хэмжээг дэмжих;	2009 - 2020			<ol style="list-style-type: none"> <li>1. Малын генетик нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд аймаг, суманд Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгж байгуулах, нэгжээр дамжуулан чанар стандартын шаардлага хангасан үржлийн малыг бойжуулж борлуулах, улмаар малын чанарыг сайжруулах ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэв. Улсын хэмжээнд нийт 131 мал үржүүлэг, технологийн нэгж үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2020 онд 35 нэгж шинээр байгуулагдсан байна.</li> <li>2. Төрийн ажил үйлчилгээг тухайн чиглэлийн төрийн бус байгууллага, мэргэжлийн нэгжээр гүйцэтгүүлэх ажлын хүрээнд үржлийн малд үзлэг ангилалт хийх, баталгаажуулах, цөм сүрэг бүрдүүлэх ажлыг улсын төсвийн 430.0 сая төгрөгийн санхүүжилтээр 56 нэгжтэй гэрээ байгуулан гүйцэтгүүлэв. Гэрээний хүрээнд хавар, намрын технологит хугацаанд 94966 бод, 131550 бог, нийт 226516 толгой малыг үзлэг ангилалтанд хамруулахаас 94566 бод, 200049 бог, нийт 294615 малыг хамруулж, гүйцэтгэл 130.0 хувьтай байна.</li> </ol>	100%

					<p>3. Баталгаажсан үүлдэр, омгийн малын цөм сүргийг бүрдүүлэх, бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэх, удам гарваль тодорхой, стандартын шаардлага хангасан малыг үржилд ашиглах зорилгоор улс болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн үзлэг ангилалтанд хавар, намрын технологит хугацаанд нийт 4.5 сая малыг хамруулж, анги чанарын үзүүлэлтийг гаргав. Үүний үр дүнд үүлдэр, омгийн малын цөм сүргээс үржлийн өсвөр малыг бойжуулж, селекци явуулах замаар малын чанарыг сайжруулах боломж бүрдэж байна.</p> <p>4. Бог малын хээлтүүлэгчийг мэргэжлийн нэгжид ялган төвлөрүүлэх замаар бэлчээрийн малын чанарыг сайжруулах, дур зоргын хээлтүүлгийг таслан зогсоох ажлыг эхлүүлж, 71 нэгжид 200.0 мянган хуц, ухныг ялган төвлөрүүлээд байна. Хуц, ухныг мэргэжлийн нэгжид ялган төвлөрүүлснээр тухайн бүс нутгийн онцлогт тохирсон, үржүүлэхийг зөвшөөрсөн, удам гарваль, ашиг шимийн чиглэл тодорхой, үржлийн бүртгэл бүхий хээлтүүлэгчээр малчид, мал аж ахуй эрхлэгчдийг хангаж, малын чанар сайжрах боломж бүрдэж байгаа болно. Уг ажлыг жил бүр хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.</p>	
32	2.2.20. Малд зайлшгүй үзүүлэх мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээний нэр төрлийг шинэчлэн тогтоож, хэрэгжүүлэх нэгжийг сум бүрт ажиллуулах;	2009 - 2020			<p>1. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор УИХ болон Засгийн газраас дараах тогтоолыг баталсан. Үүнд: 1. “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их хурлын 2018 оны 41 дүгээр тогтоолоор Мал эмнэлгийн ерөнхий газрыг байгуулав.</p> <p>2. “Засгийн газрын агентлагийн талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2018 оны 186 дугаар тогтоолоор Мал эмнэлгийн ерөнхий газрын бүтэц, орон тоог батлав.</p> <p>3. “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2018 оны 188 дугаар тогтоолоор Мал эмнэлгийн ерөнхий газрын харьяанд “Биокомбинат” улсын төсөвт үйлдвэрийн газар, “Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори” улсын төсөвт үйлдвэрийн газрыг байгуулж, Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори” улсын төсөвт үйлдвэрийн газрыг ажиллуулахаар батлав.</p> <p>4. “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2018 оны 267 дугаар тогтоолоор Аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газар, сум, мал бүхий дүүрэгт Мал эмнэлгийн тасаг байгуулахаар батлав.</p>	70%



					<p>5. Аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газар, сум, дүүргийн мал эмнэлгийн тасгийн бүтэц, орон тоог шинэчлэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны А/13 дугаар тушаалаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллав.</p> <p>6. 2018 онд Мал үржүүлэг технологийн ажил, үйлчилгээний төрөл, жишиг үнийг шинэчлэн ХХААХҮ-ийн Сайдын А-68 дугаар тушаалаар, 2019 онд "Малын үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгжийн бүтэц, үйл ажиллагаа" үндэсний стандартыг тус тус батлуулан мөрдөн ажиллаж байна.</p>	
33	<p>2.2.21. Мал, амьтны шүлхий, мялзан өвчнөөс тайван орны жагсаалтад орж, тодорхой бүс нутгийг малын гоц халдварт болон нэн аюултай зооноз өвчнөөс эрүүлжүүлэн мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортын чөлөөт байдлыг хангах, экологийн цэвэр үндэсний нэрийн бүтээгдэхүүн бий болгож гадаад зах зээлд өрсөлдөх бодлогыг алхам алхамаар хэрэгжүүлэх.</p>	2009 - 2020			<p>1. Монгол улсын баруун бүсийн Ховд, Баян-Өлгий, Увс, Завхан, Говь-Алтай, Баянхонгор, Хөвсгөл аймгийг шүлхийгүй, вакцин хэрэглэдэггүй болохыг ДМАЭМБ-аар хүлээн зөвшөөрүүлэхээр илгээх баримт бичиг (dossier)-ийг англи хэлээр бэлтгэн 2020 оны 09 дүгээр сард МЭЕГ-ын албан ёсны цахим хаягаар дамжуулан ДМАЭМБ-ын захирлын болон холбогдох цахим хаягуудаар илгээсэн.</p> <p>2. Мөн БНХАУ-аас баруун бүсийн аймгуудад тогтоосон бог малын мялзангийн хоригийг цуцлуулахаар ХХААХҮ-ийн дэд сайдаар ахлуулсан ажлын хэсэг ажиллаж байна. 2020 онд Үхрийн цээж, ямааны годрон өвчнөөс эрүүлийг баталгаажуулах шинжилгээг Мал эмнэлгийн ерөнхий газрын захиалгаар Мал эмнэлгийн хүрээлэнгийн судалгааны баг 2018 оноос хойш хийж гүйцэтгэсэн. Энэ жил уг тандалтын арга хэмжээг гүйцэтгэн 2021 оноос Үхрийн цээж, ямааны годрон өвчнөөс эрүүлийг баталгаажуулахаар ДМАЭМБ-д dossier илгээхээр төлөвлөөд байна.</p> <p>3. Үхрийн тархи сархиагтах өвчнөөс Монгол улс эрүүлийг баталгаажуулах зорилгоор 2012 оноос хойш жил махны үйлдвэрүүдэд тулгуурлан хэрэгжүүлж байна. 2021 оноос уг өвчнөөс эрүүлийг баталгаажуулах dossier-ийг ДМАЭМБ-д илгээхээр төлөвлөж байна.</p>	70%
<p>2.3. Малчдын өөрөө өөртөө туслах, өөрөө өөрийгөө удирдах иргэний нийгмийн бүтцийг бий болгон хөгжүүлэхийг дэмжих, боловсрол, мэдлэг чадварыг дээшлүүлэх, тусгай мэргэжил эзэмшүүлэх, малчдад үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах замаар амьдралын дадал, заншилд өөрчлөлт оруулах бодлогын чиглэлийн хүрээнд дараахь стратегийн зорилт дэвшүүлэн хэрэгжүүлнэ:</p>						
34	<p>2.3.1. Малчны өөрөө өөрийгөө удирдах анхан, дунд, дээд шатны байгууллага бий болгох, анхан шатны байгууллагыг</p>	2009 - 2020			<p>1. Хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн боловсруулав. "Ногоон алт малын эрүүл мэнд" төсөлтэй хамтран сумдад бэлчээрийг зөв зохистой ашиглах, талаар сургалт зохион байгуулж аймаг бүрт бэлчээр ашиглалтын хэсэг /БАХ/-тэй болж</p>	100%

	<p>удирдлага, менежмент, зохион байгуулалтын нэгдсэн хэлбэрт оруулах бүтэц бий болох боломж, нөхцөлийг бүрдүүлэх, малчдын дунд сургалт явуулж оролцооны аргаар албан ёсны зохион байгуулалтын бүтцэд шилжих үйл явцыг төрөөс дэмжин хөгжүүлэх;</p>			<p>малчид бэлчээрийг хуваарьтай ашиглах, сүргийн бүтцийг бэлчээрийн даацад тохируулан үржүүлэх зэргээр малын тоог чанарт шилжүүлэх зорилтын хүрээнд ажиллаж байна.</p> <p>2. Дархан-Уул аймагт 2017 оноос хэрэгжүүлж байгаа “МОНГОЛ МАЛЧИН” төслийн хүрээнд 4 сумын 96 малчин БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн, Сайхантал, Жининь буюу Улаанцав хотуудад малчин айлаар зочлон, ноос ноолуур, төмс, сүү, цагаан идээ болон мах боловсруулах үйлдвэрүүдтэй танилцан туршлага судласан, залуу малчид, мал бүхий иргэдийг ОХУ-ын Буриад улсад, эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр туршлага судлахад 4 сумын 50 малчин тус тус оролцлоо.</p> <p>3. Энэ онд Жайка төслөөс “Зөгийн бүлийн хаврын арчилгаа, маллагаа” сэдэвээр цахим сургалтыг зохион байгуулсан бөгөөд 51 зөгийчин уг сургалтаас мэдээлэл авсан. Төслөөс зөгийн аж ахуй эрхэлчдэд тавих хяналт, удирдлагын чиглэлээр Япон улсад 9 хоногийн сургалтад аймгийн Мэргэжлийн хяналтын болон Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2 мэргэжилтэн хамрагдсан. Сургалтаар “Зөгийн балны эрүүл ахуй болон чанар”, “Зөгийн бүл арчлах аргын үндэс”, “Зөгийн балны стандарт”, “Зөгийн балны эргэн мөшгөх тогтолцоо”, ”Зөгийн холбооны арга туршлага” сэдэвт 9 хоногийн сургалтад хамрагдсан.</p> <p>4. МУСҮТөвтэй Баян-Өлгий аймагт энэ жил бүх сургалтыг цахим хэлбэрт шилжүүлсэнтэй холбоотой ZOOM програмыг ашиглан ХХАА-н салбартай холбогдолтой хууль, тогтоомж, малын чанарыг сайжруулах, Монгол мал үндэсний хөтөлбөрийн зорилго, МАА-н үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр, ноос, арьс шир, ноолуурын урамшууллын талаар сумдын хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэнүүд болон мал аж ахуй эрхлэгчдийн төлөөллийг оролцуулан нийтдээ 6 удаа сургалт зохион байгуулсан. Цахим сургалтанд 436 хүн хамрагдав. 2020 онд 2487 малчин цахим сургалт сурталчилгаанд хамрагдаж, арга зүйн зөвлөгөө авсан байна.</p>	
35	<p>2.3.2. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид болон малчид сайн дураар нэгдэн төрийн бус байгууллага, холбооны зохион байгуулалтад орох боломж, нөхцөлийг бүрдүүлэх;</p>	2009 - 2020		<p>1. "Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих" үндэсний хөтөлбөрийг ЗГ-ын 2018 оны 400 дугаар тогтоолоор баталсан. Тус хөтөлбөрт эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид болон малчид сайн дураар нэгдэн төрийн бус байгууллага, холбооны зохион байгуулалтад орох боломжийг зохицуулж өгсөн. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн мэргэжлийн 8 холбоо төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжих чиглэлээр тогтмол үйл ажиллагаа явуулж байна.</p>	100%

36	2.3.3. Малчдын бүлэг, хоршоо, нөхөрлөл, холбоог бэхжүүлэх зорилгоор тэдгээрийг гадаад улс, олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй дунд, урт хугацааны төсөл, хөтөлбөрт хамруулах;	2009 - 2020			<ol style="list-style-type: none"> <li>1. Ази-Номхон далайн бүсийн фермерүүдийн хөтөлбөрийг “ХАА-г хөгжлийг дэмжих олон улсын сан” санхүүжүүлж байгаа бөгөөд Хөдөөгийн тогтвортой хөгжлийн төлөөх Азийн фермерүүдийн холбоогоор дамжуулан Үндэсний холбоо энэхүү хөтөлбөрийг Монгол улсад хэрэгжүүлэхээр сонгогдон ажиллаж байна.</li> <li>2. “ХАА-н хөгжлийг дэмжих Олон улсын сан”-ийн санхүүжилтээр хэрэгжиж буй Ази-Номхон далайн бүсийн фермерүүдийн хөтөлбөрийн хүрээнд өрхийн хэмжээнд хүнсний үйлдвэрлэл эрхэлж буй жижиг аж ахуй эрхлэгч нарын хөдөлмөрийг үнэлэх, дэлхий нийтийг хамарч буй аюулт өвчнийг даван туулахад тэдэнд итгэл найдвар, урам зориг өгөх зорилгоор “FOOD HERO” буюу “Хүнсний баатрууд” хөдөлгөөнийг Ази номхон далайн бүсийн хэмжээнд өрнүүлж байна.</li> <li>3. Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын холбоо нь “ХАА-н хөгжлийг дэмжих олон улсын сан”/IFAD/-ийн Монгол Улсыг хариуцсан захирал Үберт Бойрард-тай хамтын ажиллагааны Санамж бичиг 2020 оны 01-р сарын 27-ны өдөр байгуулж гарын үсэг зурсан. Энэхүү санамж бичгийг байгуулснаар “ХАА-н хөгжлийг дэмжих Олон улсын сан”-аас хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрүүдийг хамтран хэрэгжүүлэх, Үндэсний холбооны гишүүн хоршоодыг төсөл хөтөлбөрт хамруулах боломж нээгдсэн байна. Санамж бичгийн хүрээнд “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн нэмэлт санхүүжилтээр Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Өвөрхангай, Дундговь, Архангай, Говь-Алтай, Хөвсгөл, Булган зэрэг төслийн зорилтот аймгуудын орон нутгийн бага дунд орлоготой иргэдийн орлогыг бодитоор нэмэгдүүлэн тэдгээрийн амьжиргааг тогтвортой болгох зорилгоор Үндэсний холбоо гишүүн хоршооддоо чадавхийн үнэлгээ хийх, 4Р бизнес төлөвлөгөө боловсруулах ажлыг зохион байгуулан ажилласан байна.</li> <li>4. Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас хэрэгжүүлж буй “Малчдын нийгмийн хамгааллыг өргөжүүлж, цочролд бэлэн байх чадавхийг нэмэгдүүлэх нь” төсөл нь 2020 оны 07-р сараас 2021 оны 12 сар хүртэлх хугацаанд Завхан аймгийн Их-Уул, Тэс, Отгон, Дөрвөлжин, Идэр сумдад хэрэгжиж байна.</li> </ol>	100%
37	2.3.4. Малчид, малчин өрх, мал аж ахуйн үйлдвэрлэл, зах зээлийн талаархи мэдээллийн	2009 - 2020			<ol style="list-style-type: none"> <li>1. ХХААХҮЯ-ны дэргэд малчин лавлах-109 мэдээллийн төвийг үйл ажиллагааг тогтмол явуулж малчид, малчин өрх, мал аж ахуйн</li> </ol>	90%

	цогц сан бий болгон ажиллуулж малчдыг мэдээллээр хангах;				үйлдвэрлэл, зах зээлийн талаархи мэдээллийг хүргэн ажиллаж байна.	
38	2.3.5. Хөдөөгийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах талаар тусгайлсан төсөл, хөтөлбөрийг бүс нутгийн онцлог байдлыг харгалзан боловсруулж хэрэгжүүлэх;	2009 - 2020			1. Монгол Улсын хүн амын 38.6 хувь нь хөдөө орон нутагт амьдарч байна. Улсад хэмжээнд ажиллаж байгаа бүх сум, сум дундын эмнэлэг нийтдээ 2020 онд 7580 ортой буюу нэг эмнэлэгт ойролцоогоор 18 ор, өөрөөр хэлбэл хөдөөгийн 1000 хүн ам тутам 5.2 ор байгаа нь өндөр үзүүлэлт юм. Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, олон улсын төсөл хөтөлбөрийн хүрээнд өрх ба сумын эмнэлгийн байр байшин, багаж хэрэгсэл, унааны үнэлгээг хийж, дараа нь засах, шинэчлэх, барилга барих, шинэ тоног төхөөрөмжөөр хангах хөтөлбөрүүдийг бүс нутгийн онцлог байдлыг харгалзан боловсруулан хэрэгжүүлж байна. Үүний үр дүнд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний чанар, хүртээмж 5 функтээр өссөн байна.	70%
39	2.3.6. Малчдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол, бүрэн хамруулж, зардлыг төрөөс хариуцах арга хэмжээг хэрэгжүүлэх, сум, багийн эмнэлгийг боловсон хүчнээр хангах, мэргэжил дээшлүүлэх богино хугацааны болон зайны сургалтад хамруулах;	2009 - 2020			1. Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, шатлал хоорондын зохицуулалтыг боловсронгуй болгох замаар Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмж болгож байгаа “Хэнийг ч орхигдуулахгүй байх” зарчмыг баримтлан “Бүх нийтийн эрүүл мэндийн хамралт”-ыг хэрэгжүүлж “Хүн төвтэй тусламж үйлчилгээний цогц загвар”-ыг бий болгохыг зорин ажиллаж байна. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж хангалтгүй байгаа төвөөс алслагдсан болон эмзэг бүлгийн хүн ам, малчдад сум, өрхийн эмч мэргэжилтнүүдээр дамжуулан хүргэж байгаа эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төрөл, хэлбэрийг өргөжүүлж, мобайл технологийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. 2015-2020 онд ДЭМБ, Солонгосын олон улсын эрүүл мэндийн сан, Солонгосын иргэдийн сангийн дэмжлэгтэйгээр 21 аймгийн 84 сумын ЭМТ, аймаг, дүүргийн 11 Өрхийн ЭМТ нийт 81 анхан шатны эрүүл мэндийн байгууллагыг 25 нэр төрлийн нэн шаардлагатай зөөврийн мобайл тоног төхөөрөмж, оношлуур, хэрэгслээр хангаж, эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүдийг чадавхижуулах сургалтад хамруулж, эмнэлзүйн сурах бичиг, гарын авлагаар хангасан. 2. Малчдын эмнэлэгт ирэлтийн материалаар бүртгэгдсэн өвчлөл, эмч нарын үзлэгээр анх удаа илэрсэн өвчлөлийг нэгтгэн “нийт буюу үнэн” өвчлөлийг гаргахад 1000 хүнд 1245,0 промели байгаагаас амьсгал /338,5/, хоол боловсруулах /298,1/, цусны эргэлтийн /148,3/	100%

					мэдрэл мэдрэхүй /114,4/ шээс бэлгийн эрхтэн, системийн өвчин эхний 5 байранд буюу нийт өвчлөлийн 78,7 хувийг эзэлж байна. Сумын эмнэлэгт ирж үзүүлэгсдийн 22,0 хувь буюу жилд 1000 хүний 123,6 нь хэвтэн эмчлүүлж байгаагийн 15-17,8 хувь нь малчид байна. Амьсгалын /64,5/, хоол боловсруулах эрхтний /15,8/, халдварт паразитын өвчний/10,9/, цусны эргэлтийн тогтолцооны өвчнөөр /5,5/ зонхилон хэвтж байна. Хүүхдийн хувьд 1000 хүнд амьсгалын /92,2/, хоол боловсруулах эрхтний /18,3/, халдварт паразит өвчний /15,8/ зонхилон хэвтж байгаа нь нийт хэвтэлтийн 87.2 хувийг эзэлж байна.	
40	2.3.7. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн сөрөг нөлөөллийг судалж, мал, амьтнаас хүнд дамжин халдварлах өвчнөөс малчид, хүн амыг хамгаалах болон осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх, ахуйн болон ундны цэвэр усаар хангах хөтөлбөр хэрэгжүүлэх;	2009 - 2020			1. Малын бруцеллэзтой тэмцэх стратеги, төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор тандалтыг 2011 онд “Монгол мал” үндэсний хөтөлбөр болон “Малын эрүүл мэнд” хөтөлбөрийн хүрээнд сүүлийн хоёр жил дараалан (2018, 2019) 17, 20 аймаг, нийслэл хотын хээлтүүлэгч малд тус тус хийж гүйцэтгэсэн. Энэ онд мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2020 оны А/038 дугаар тушаал, түүний хавсралтаар бруцеллэзын хээлтүүлэгчийн тандалт шинжилгээ-2020 ажлыг зохион байгуулсан. Хээлтүүлэгч малын бруцеллэзын шинжилгээнд 325 сум, дүүргийн 1,236 баг, 55,053 өрх айлаас 262,509 сорьц авч, гүйцэтгэл нийт дүнгээр 91.5% дүнтэй буюу өрхийн тоо олон хамрагдсан дүнтэй гарсан. РБУ-аар нийт эерэг 262,509 мал шинжилснээс 496 буюу 0.19%-д эсрэг бием илэрсэн байна. Шинжилгээгээр эерэг буюу өвчтэй гарсан хээлтүүлэгчийг хөнгөлж, хэрэгцээлсэн байна. 2019 онд Улаанбаатар хот орчмын үхэр бүрэгт бруцеллэзын эрүүлийг баталгаажуулах шинжилгээг 34,0 мянган үхэрт хийж, Мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2020 онд хэлэлцүүлэн "Бруцеллэзоос эрүүл сүрэгтэн" гэрчилгээг 14 аж ахуйн нэгжид олгоод байна. Ингэснээр нийтийн хэрэгцээнд эрүүл, аюулгүй сүү, сүүн бүтээгдэхүүн нийлүүлэх, цаашид урамшуулах хөшүүргийг бий болгоод байна. Малаас хүнд дамжин халдварладаг боом, бруцеллэз, галзуу зэрэг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг улсын хэмжээнд зохион байгуулж, хүн амыг бэтэг өвчнөөс сэргийлэх зорилгын хүрээнд Улсын хэмжээнд нийт 289,3 мянган толгой нохой туулгалтад хамрагдаж, төлөвлөгөөний биелэлт 84%-тай байна.	90%
41	2.3.8. Малчин өрхийн эдийн засаг, бизнес, ур чадварын түвшинд нийцсэн сургалтын ялгавартай хөтөлбөр бий	2009 - 2020			1. Тогтвортой ноос, ноолуурын эвсэл, Мэргэжлийн боловсрол сургалтын үнэлгээ, мэдээлэл арга зүйн төвтэй хамтран "Малчин мэргэжлийн ажил мэргэжлийн" стандартыг батлуулж, сургалтын хөтөлбөрийг боловсруулан 5 мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн	100%

	болгож хөгжүүлэх, сургагч багш нарыг сум бүрт бэлтгэж мэргэшүүлэх;				төвтэй хамтран 125 малчинд сургалтыг зохион байгуулсан. Мөн мэргэшсэн 12 багшаар дамжуулан ноолуур бэлтгэн нийлүүлэгч гишүүн 1500 эмэгтэйд сургалт явуулсан байна.	
42	2.3.9. Малчдад зориулсан сургалтыг орон нутагт үйлдвэрлэлийн явцад хэрэгжүүлэх байгууллага, малчны байнгын болон түр сургуулийг бий болгон бэхжүүлэх, түүгээр дамжуулан шат дараалсан сургалт (анхан шатны танин мэдэхүйн сургалтаас эхлээд технологи дамжуулах, нутагшуулах, инноваци нэвтрүүлэх зэрэг)-ыг зохион байгуулах;	2009 - 2020			1. Улсын хэмжээнд 5 аймагт МСҮТ дээр малчдад зориулсан сургалтын хөтөлбөрийн дагуу шат дараалсан сургалтыг зохион байгуулж байна. Анхан болон ахисан түвшиний сургалтанд нийт 1200 гаруй малчин хамрагдаж төгссөн байна.	100%
43	2.3.10. Залуу болон ирээдүйн малчдыг мэргэжлийн, түр болон албан бус сургалтаар хэтийн төлөвлөгөөтэй бэлтгэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх, малчдад зориулсан зайны сургалтын хөтөлбөрийг боловсруулж хэвлэл, мэдээллийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;	2009 - 2020			1. Малчин мэргэжлийн ажил мэргэжлийн лавлахыг Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны ажил мэргэжлийн стандарт боловсруулах төв боловсруулж, Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын зөвлөлөөр баталгаажуулсан байна.	100%
44	2.3.11. Малчдад зориулсан сонин, сэтгүүл тогтмол гаргахыг дэмжих, мэдээллийн хэрэгслээр мэдээлэл, тусгай хөтөлбөрийг боловсруулж хэвлэл, мэдээллийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;	2009 - 2020			1. Малчин лавлах-109 төв, монгол малчин сэтгүүлийг улирал тутам гаргаж 21 аймгийн 330 суманд захиалга авч түгээж байна. Мөн малчин телевизтэй хамтран малчдыг соён гэгээрүүлэх, мэдлэг чадварыг дээшлүүлэх чиглэлээр нэвтрүүлэг, мэдээ бэлтгэн хамтран ажиллаж байна.	100%
45	2.3.12. Орлого багатай малчдыг бусад төрлийн аж ахуй эрхлэх, бие даан бизнес эрхлэх ур	2009 - 2020			1. МУ-н ЗГ-ын 34 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол малчин” үндэсний хөтөлбөр болон Хөдөлмөр халамж үйлчилгээний Ерөнхий газраас зохион байгуулалттай ажлын байр туршилтын төсөл	100%

	<p>чадварыг дээшлүүлэх тусгай хөтөлбөр хэрэгжүүлэх, тэдний хэрэгцээ, чадавхи, санаачилгыг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагааг үндэсний болон олон улсын төсөл, хөтөлбөрөөр дамжуулан хэрэгжүүлэх;</p>			<p>хэрэгжүүлсэн. Энэхүү хөтөлбөр арга хэмжээний хүрээнд хот, суурингаас хөдөөд шилжин суурьшиж, мал маллах хүсэлтэй гэр бүл болон туслах малчинг цалин хөлстэй ажилд зуучилж, тогтвортой ажлын байр, орлоготой болгоход чиглэгдсэн юм. Улмаар энэ оны эхний улирлын байдлаар нийт 627 иргэн хамрагдаж 108,002.7 мянган төгрөг зарцуулж 547 ажлын байр бий болсон байна. Тодруулбал, Сумын ажилгүй иргэдийг бүлгийн зохион байгуулалттайгаар хөдөлмөр эрхлүүлэх арга хэмжээнд 21 аймгийн 84 бүлгийн 421 иргэд хамрагдаж 87,003.2 мянган төгрөгийг; Хорооны ажилгүй иргэдийг багийн зохион байгуулалттайгаар хөдөлмөр эрхлүүлэх арга хэмжээнд 9 дүүргийн 56 багийн 537 иргэд хамрагдаж 40,475.8 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.</p> <p>2. Өрхийн аж ахуй, бичил бизнес эрхлэгчдийг өртөг шингэсэн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны 1 дүгээр тогтоолоор баталсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн хүрээнд 10.0 хүртэл сая төгрөгийн итгэлийн зээл буюу санхүүгийн дэмжлэгийг 24-48 сарын хугацаанд 100 хувь эргэн төлөх нөхцөлтэйгээр олгох арга хэмжээг Улсын хэмжээнд буюу 21 аймагт хэрэгжүүлж байна.</p> <p>3. “Ноолуур” хөтөлбөрийн хүрээнд олгогдож буй хөнгөлөлттэй зээл болон ноосны урамшуулалд хамрагдсан. -Хонь, тэмээний ноос бэлтгэж, үндэсний үйлдвэрт тушаасан малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох” журмыг шинэчлэн боловсруулж Засгийн газрын 2019 оны 09 дүгээр сарын 4-ний 343-р тогтоолоор батлуулав.</p>	
46	<p>2.3.13. Малчдын хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулах оновчтой арга механизмыг бий болгох, ерөнхий боловсрол эзэмших болон мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд суралцахад нь дотуур байраар хангахад төрөөс дэмжлэг үзүүлэх.</p>	2009 - 2020		<p>1. Мэргэжлийн байгууллага, гадаад дотоодын төсөл, хөтөлбөрийн хүрээнд малчдад мал маллагааны арга туршлага эзэмшүүлэх, аж ахуй эрхлэх арга ажиллагаанд сургах, бүтээгдэхүүн, түүхий эд боловсруулах, ургамал хамгаалах, тэжээл бэлтгэх, эрчимжсэн аж ахуй болон жижиг, өрхийн үйлдвэрлэл эрхлэх, мал үржүүлэх, мал эмчлэн сэргийлэх чиглэлээр 2020 оны байдлаар 125 сум, дүүрэгт давхардсан тоогоор 720 гаруй тэнхимийн болон цахим сургалт зохион байгуулж 56.3 мянган малчинг хамруулав.</p> <p>2. Ерөнхий боловсролын сургуульд сурч буй малчдын хүүхдийг 100 хувь дотуур байраар хангаад байгаа төдийгүй Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 59 дотуур байранд 3800 гаруй малчны хүүхдийг хамруулж байна. Малчин өрхийн бага насны хүүхдэд</p>	100%

					<p>сургуулийн өмнөх боловсрол олгох талаар: Малчин өрхийн баг насны хүүхдэд сургуулийн өмнөх боловсролыг хувилбарт сургалтын ээлжийн болон нүүдлийн бүлэг, явуулын багшийн сургалтаар олгож байгаа бөгөөд 2019-2020 оны хичээлийн жилийн статистикийн мэдээлэлээр малчин өрхийн 34.8 мянган хүүхэд сургуулийн өмнөх боловсролд үнэ төлбөргүй хамрагдаж байна. Эдгээр хүүхдийн 25.7 мянга нь хувилбарт сургалтад 8.7 мянга нь үндсэн сургалтад тус тус хамрагдаж байна.</p>	
--	--	--	--	--	--	--

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**